

Гарчиг

2-3 Үнэт цаасны зах зээлийн бодлого зохицуулалтын орчин

Зохицуулалтын мэдээ (4-7)

Монгол Улсад анх удаа давхар бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эхэллээ; 11, 12 дахь хөрөнгө оруулалтын сангууд байгуулагдав; “Монголын компанийн засаглалын форум 2018” боллоо; AFI бүс нутгийн тав дахь зөвлөлийг шинээр байгуулахаар боллоо; “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлээ; MSE А болон MSE В; Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа; Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн асуудлаар ҮЦХОУБ зөвлөмж гаргахаар боллоо; Даатгалын зах зээлд мөрдөж буй зарим журам, заавар, стандартыг шинэчлэн баталлаа;

8 Компаниуд ногдол ашиг тараадаг болоход хувьцаа эзэмшигчдийн санаачилга дутаад байна

10 Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сан бий болгох хэрэгцээ, шаардлага

12 Санхүүгийн технологийн хөгжил

13 2018 оны хөрөнгийн зах зээлийн гол чиг хандлагууд

15 Банк бус санхүүгийн болон Даатгалын салбарын удирдах ажилтнуудын уулзалтыг зохион байгууллаа

17 А.Авир: Омбудсмений тогтолцооны эрх зүйн орчныг бий болгоно

19 Иргэдийн өргөдлийг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Зах зээлийн мэдээ (20-21)

Санхүүгийн зах зээлд итгэх иргэдийн итгэлийн индексийг танилцууллаа

22 Давхар бүртгэлийн журам

23 Ипотекийн зээлийн даатгал

Санхүүгийн мэдээллийн шинэ гарц

Санхүүгийн салбарт итгэх олны итгэлийг өргөжүүлэн тэлж, бататган бэхжүүлэхийн тулд мэдлэг, мэдээллийг бүхий л боломжоороо дэлгэрүүлэх ажлыг тасралтгүй хийх шаардлага тулгарч байна.

Эдийн засаг, нийгмийн бүхий л салбарын хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь мэдлэг, мэдээлэл юм. Тэр дундаа улс орны нийт хүн ам, тэдний амьдрал ахуй, ажил хэрэг, өдөр тутмын хэрэглээ, хэрэгцээ шаардлагад хамаарч байдаг санхүүгийн салбарын мэдээлэл, иргэд, харилцагч, үйлчлүүлэгчдийн мэдлэг, боловсрол эргээд санхүүгийн салбарынхаа хөгжил дэвшил, тогтвортой байдалд чухал үүрэгтэй. Дэлхий дахинаа улс орон бүр өнөөдөр хүртээмжтэй санхүү буюу inclusive finance гэсэн нийтлэг чиг баримтлалыг дэвшүүлэн, олон нийтийн санхүүгийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилтыг энэ бодлогынхоо цөм болгон авч үзэж байна.

Санхүүгийн зохицуулах хороо банкнаас бусад санхүүгийн салбар буюу үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж, зээлийн хоршооны салбарт тогтвортой байдлыг хангах, олон улсын стандарт, тулгуур зарчмуудыг нэвтрүүлж зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, зах зээлд оролцогчдын чадавхыг бэхжүүлэх, мэргэшүүлэх бодлого баримтлан ажиллаж буйн зэрэгцээ санхүүгийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлж, хэрэглэгч, харилцагчдын итгэлийг бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулж байна.

Санхүүгийн үйл ажиллагаа бол итгэлд тулгуурладаг бизнес. Энэ итгэлийг бий болгож, өргөжүүлэн тэлж, бататган бэхжүүлэхийн тулд бодлого, зохицуулалтын мэдээлэл болон зах зээлийн статистик, тоо баримт, олон улсын хөгжлийн хандлага,



С.Даваасүрэн

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор

судлаачдын байр суурь төдийгүй эдийн засаг, санхүүгийн судлалын анхан шатны ойлголтыг хүртэл бүхий л боломжоороо түгээн дэлгэрүүлэх ажлыг тасралтгүй хийх шаардлага тулгарч байна. Иймд бид иргэд, олон нийт болон салбарын мэргэжилтнүүд, зах зээлийн оролцогчиддоо мэдээлэл хүргэх нэгэн шинэ гарц бий болгох зорилгоор “Хүртээмжтэй санхүү” товхимлыг тогтмол гаргахаар санаа нийлэн, анхны дугаарыг уншигч Таны гарт хүргэж байна.

Товхимлынхоо анхны дугаарт бид үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын ерөнхий асуудлуудыг хөндсөн бөгөөд цааш цаашдын дугаартаа тодорхой сэдвийг гоцлол болгон дэвшүүлж байх юм. Уншигч Таны санал, зөвлөгөө бидний ажилд маш их тус дэм болох тул Хорооны үйл ажиллагаа, санхүүгийн салбарын зохицуулалт, зах зээлийн талаар ямар мэдээлэл авахыг хүсч буйгаа илэрхийлж, хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Компаниуд ногдол ашиг тараадаг болоход хувьцаа эзэмшигчдийн санаачилга дутаад байна

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэнтэй ярилцлаа.

-Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас идэвхтэй арилжаанд ордог нь хэд вэ

-2018 оны гуравдугаар сарын 21-ний байдлаар 300 хувьцаат компани Хороонд бүртгэлтэй байна. Үүнээс 65 ХК-ийн үйл

ажиллагаа зогссон. Хөрөнгийн биржид бүртгэлтэй 219 хувьцаат компани байна. Идэвхтэй арилжаанд оролцдог нь цөөхөн шүү дээ.

-Энэ компаниудын хэд нь ногдол ашгаа тогтмол тараадаг бол?

Иргэлжлэл 8, 9-р нүүрт

Санхүүгийн зохицуулах хорооны

Алсын хараа

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт, тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож, эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

Эрхэм зорилго

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж, олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

Үнэт зүйлс

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

Монгол Улс, Улаанбаатар хот 15160
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IV байр.

976 51 261611

press@frc.mn

www.frc.gov.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC_of_Mongolia

Хэвлэл мэдээллийн алба

"БиСиАй" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

Үнэт цаасны зах зээлийн бодлого зохицуулалтын орчин

"Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-т дунд хугацаанд зохицуулалтын байгууллагаас шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлуудыг тодорхойлж, тусгасан.



Б.Төмөрхуяг

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын мэргэжилтэн

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO) нь 1983 онд үүсгэн байгуулагдсан ба дэлхийн үнэт цаас болон фьючерсийн зах зээлийг зохицуулагч байгууллагуудыг нэгтгэсэн олон улсын байгууллага бөгөөд үнэт цаасны салбар дахь олон улсын стандартыг тогтоох зорилготой юм. Түүнчлэн үнэт цаасны зохицуулалтын стандартын хоорондын уялдаа холбоог нэгтгэн хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Гишүүд нь ихэвчлэн улс болгоны Үнэт цаасны хороод буюу санхүүгийн зохицуулагч байгууллагууд байдаг. ҮЦХОУБ (IOSCO) нь дэлхийн үнэт цаасны зах зээлийн 95 хувийг зохицуулдаг 100 гаруй гишүүн оронтой. ҮЦХОУБ-ын хороод нь хэд хэдэн бүтцээс бүрддэг ба дэлхийн аль нэг улсад жилд хэд хэдэн удаа хурал хийдэг.

ҮЦХОУБ-д нэгдэн орсноор Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн орчин, зохицуулалтын тогтолцоо нь олон улсын жишигт нийцсэн болохыг ҮЦХОУБ-аас хүлээн зөвшөөрч, баталгаажуулж байгаа хэрэг юм. Олон талт хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурснаар Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү санамж бичигт нэгдэн орсон 218 үнэт цаасны зохицуулалтын гишүүн байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох хамтран ажиллах боломж бүрдэж байгаа юм.

Олон талт санамж бичигт үзэглэсэн гишүүн орнуудын санхүүгийн зах зээлийн хууль эрх зүйн зохицуулалтыг жигдрүүлэх, энэ чиглэлээр хамтран ажиллах, санхүүгийн зах зээлийн хяналт шалгалтыг сайжруулж, зохицуулагч байгууллагын олон улс дамнасан хэрэг дээр хяналт шалгалт хийх чадавхыг бэхжүүлэх зорилготой. Мөн олон улсын хүрээнд хууль дүрэм журмыг хэрэгжүүлэх зорилгоор мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх зэрэг оролцоог баталгаажуулсан баримт бичиг юм. Олон талт санамж бичиг зурж гишүүн болсон улс хууль эрх зүйн хувьд

дараах чадамжтай байх ёстой. Үүнд:

- Үүссэн хэрэгтэй холбогдуулан хянан шалгах зорилгоор мэдээлэл гаргуулах;
- Санамж бичигт дурдсан хэлбэрээр бусад гишүүн орнуудыг мэдээллээр хангах;
- Мэдээллийн нууцлалыг хадгалах.

ҮЦХОУБ нь энгийн гишүүн /ordinary/, хамтрагч гишүүн /associate/, түнш гишүүн /affiliate/ гэсэн 3 хэлбэрээр гишүүдээ элсүүлдэг. Энгийн гишүүд (128) гэсэн төрөлд нь ихэвчлэн улс бүрийн зохицуулагч байгууллагууд элсэн ордог. Хамтрагч гишүүн (27) төрөлд хэд хэдэн улсын хөрөнгийн зах зээл хяналтаа тогтоосон байгууллага элсэн орох боломжтой. Түнш гишүүн (63) төрөлд санхүүгийн зах зээлд арилжааны, төлбөр тооцоо хадгаламжийн болон өөрийгөө зохицуулах байгууллагууд элсэн ордог.

Мөн тус байгууллага нь дотроо бүсчилсэн дэд хороодтой. Үүнд:

1. Ази-Номхон Далайн бүс нутгийн дэд хороо (Монгол улс энэ хорооны гишүүн);
2. Европын бүс нутгийн дэд хороо;
3. Африк болон Ойрх Дорнод бүсийн дэд хороо;
4. Америк бүс нутгийн дэд хороо.

Үүнээс гадна дэд хороо байх ба үүнээс хамгийн том нь Хөгжиж буй зах зээлийн дэд хороо бөгөөд нийт энгийн гишүүдийн 75% нь энэ дэд хорооны гишүүн байх ба Монгол улс мөн энэ дэд хорооны гишүүн юм. Бүх гишүүдийн хурал ба дэд хорооны хурлаас гадна тус байгууллага нь зах зээлийн тулгамдаж буй асуудал, шаардлагатай байгаа сэдвүүдээр тогтмол сургалтуудыг гишүүн орнууддаа зохион байгуулдаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь ҮЦХОУБ-ыг удирдах болон стандарт тогтоох байгууллага бөгөөд 34 зохицуулагч гишүүдээс бүрддэг. Хонг Конг-ийн Үнэт цаас, Фьючерсийн хорооны гүйцэтгэх захирал ноён Эшли Иан Алдер нь ТУЗ-ийн даргаар ажилладаг. ҮЦХОУБ-ын удирдах зөвлөл нь 2015 оны уулзалтаар 2016-2020 оны зорилгоо дараах байдлаар баталсан байна. Үүнд:

2016-2020 оны зорилт:

1. Хөрөнгө оруулагчдыг хамгаалах,

шударга, үр ашигтай, нээлттэй зах зээлийг бүрдүүлж, системийн эрсдэлээс сэргийлэхийн тулд олон улсад баримталж буй бодлого, хяналт, шалгалтын зохицуулалт, үзэл баримтлалыг хэрэгжүүлэх цаашид хөгжүүлэхэд хамтран ажиллах;

II. Мэдээлэл солилцоо, зах зээлд оролцогчдын зүгээс гаргасан зөрчлийг хянаж шалгах, хуулийн арга хэмжээ авах замаар хөрөнгө оруулагчдыг хамгаалах механизмыг сайжруулах, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлийн шударга байдалд итгэх итгэлийг дээшлүүлэх;

III. Зах зээлийн хөгжлийн явцад зохистой зохицуулалт, дэд бүтцийг бэхжүүлэхэд зөвлөгөө өгөх үүднээс олон улсын болон бүс нутгийн хүрээнд мэдээлэл солилцох.

Санхүүгийн зохицуулах хорооны ҮЦХОУБ-д элсэн орох үйл ажиллагаа нь 2003 оноос эхэлсэн бөгөөд анхлан Үнэт цаасны хороо нэрээр энгийн гишүүний эрхийг 2003 оны 10 дугаар сарын 27-ны өдөр авч байсан түүхтэй.

2006 онд Санхүүгийн зохицуулах хороо болж өөрчлөн байгуулагдсан нь ҮЦХОУБ-д ахин гишүүнээр элсэх шаардлагыг бий болгосон. Гишүүнээр элсэн ороход шат дараатай техник туслалцаа, үнэлгээ хийх шаардлагатай байдаг бөгөөд энэ хүрээнд 2007 оны 12 дугаар сарын 17-ноос 2008 оны 4 дүгээр сарын 30-ны хооронд ҮЦХОУБ-ын шинжээч Монголын санхүүгийн салбарын хууль эрх зүйн зохицуулалт, тулгарч буй асуудлууд, ҮЦХОУБ-ын асуулгыг бөглөхөд туслалцаа үзүүлэх зэргээр хамтран ажилласан байдаг.

2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн найруулж, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаар эрх зүйн зохицуулалт боловсронгуй болж, 2014 оны 6 дугаар сарын 18-нд Санхүүгийн зохицуулах хороо нь олон талт санамж бичигт гарын үсэг зурснаар Монгол Улс гишүүн болж элсэн орсон байна.

Хороо нь гишүүн байгууллага болохын хувьд, ҮЦХОУБ-аас гаргасан зарчим, зөвлөмжийг зах зээлийн бодлогын баримт бичигт тусгуулах болон зохицуулалт, хяналтын орчныг шинэчилж ажилладаг. Иймд санхүүгийн зах зээлийн хөгжлийн дунд хугацааны баримт бичиг болох "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Сангийн яам болон Монголбанктэй хамтран боловсруулах хүрээнд нэн тэргүүнд үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчны үнэлгээг тус байгууллагаас гаргасан аргачлалын дагуу гүйцэтгэсэн. Энэ нь ҮЦХОУБ-ын 10 бүлгийн

38 зарчмын хэрэгжилт тухайн улс орны хувьд хэр өндөр гүйцэтгэлтэй байгааг үнэлдэг бөгөөд үнэлгээний үр дүнд үндэслэн дунд хугацаанд зохицуулалтын байгууллагаас шийдвэрлэх шаардлагатай байгаа асуудлуудыг тодорхойлж, улмаар хөтөлбөрт тусгасан. Өөрөөр хэлбэл үнэлгээний үр дүнд санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчныг сайжруулах хэрэгцээ, шаардлага тодорхой болж, хөтөлбөрт тусгалаа олсон юм.

Мөн ҮЦХОУБ-ын 2016-2020 оны зорилт болох хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилтыг өөрийн оронд хэрэгжүүлэх зорилгоор "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох" үндсэн чиглэлд Хөрөнгө оруулагчийг хамгаалах сангийн тухай хуулийн (ХОХС) төслийг боловсруулахаар тусгасан. Энэхүү хуулийн төслийг боловсруулснаар хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт сайжрах, үүнийг дагаад үнэт



цаасны арилжааны хэмжээ нэмэгдэх, мэргэшсэн санхүүгийн зуучлагч компаниуд үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэнээр хөрөнгө оруулагчдын хөрөнгө найдвартай хамгаалагдаж, харилцагч үнэт цаасны компаниуд төлбөрийн чадваргүй болсноос үүдэн хөрөнгөө алдах эрсдэлийг бууруулж, нөхөн олговрын систем бүрдэхээс гадна уг сан нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд дэмжлэг үзүүлж, системийн хэмжээнд учрах эрсдэлийг бууруулах боломжтой юм.

Монгол Улсад ХОХС-ийн эрх зүйн зохицуулалтыг бий болгосноор дараах давуу талууд бий болох юм. Үүнд:

- Тусгай хуулийн дагуу үнэт цаасны компаниуд нь хөрөнгө оруулагч, харилцагчдын мөнгөн хөрөнгө, хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг өөрийн хөрөнгөнөөс тусад нь салгаж бүртгэхээр зохицуулагдсанаар хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар, зөвшөөрөлгүй ашиглах эрсдэлийг бууруулж, хөрөнгийн ил тод байдлыг сайжруулах;
- ХОХС нь нөхөн олговрыг зөвхөн энгийн буюу жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад олгох бөгөөд засгийн газар, институциональ хөрөнгө оруулагчид хамрагдахгүй байхаар зохицуулсан нь олон тооны бага хэмжээний хөрөнгө

оруулалт хийсэн жижиглэнгийн хөрөнгө оруулагч, иргэдийг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх;

- ХОХС сангийн хөрөнгийг удирдахдаа зөвхөн ЗГ-ын бонд, банкны депозит, Ерөнхий сайд, Сангийн яамнаас батламжилсан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийгдэхээр зохицуулагдсан нь нөхөн олговор олгох үед төлбөрийн чадваргүй болох, сангийн хөрөнгийг зохисгүй удирдах зэрэг эрсдэлээс хамгаалагдах юм.

ХОХС-ийн эрх зүйн орчинг бүрдүүлснээр тус зах зээлд дараах эерэг өөрчлөлт гарна. Үүнд:

- Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэнээр хөрөнгө оруулагчдын хөрөнгө найдвартай хамгаалагдаж, харилцагч үнэт цаасны компаниуд төлбөрийн чадваргүй болсноос үүдэн хөрөнгөө алдах эрсдэлийг бууруулж, нөхөн олговрын систем бүрдэнэ;
- Хөрөнгийн зах зээлд итгэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэнэ;
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдсэнээр үнэт цаасны арилжааны хөрвөх чадвар нэмэгдэнэ;
- Үнэт цаасны компаниуд ХОХС-ийн гишүүн болсноор өрсөлдөх чадвар, нэр хүнд өсч, үйл ажиллагааны цар хүрээ нь нэмэгдэнэ;
- Хөрөнгийн зах зээлийн хөгжилд дэмжлэг үзүүлж, системийн хэмжээнд учрах эрсдэл буурна.

Д а ш р а м д дурьдахад ҮЦХОУБ нь жил болгон ээлжит хуралдаанаа зохион байгуулдаг бөгөөд 43 дахь удаагийн хуралдаан

2018 оны 5 дугаар сарын 7-оос 11-ний өдрүүдэд Унгарын Будапешт хотноо зохион байгуулагдлаа. Тус хуралдааны үер гишүүн орнууд дэлхийн үнэт цаасны болон фьючерсийн зах зээлд өрнөж буй чухал асуудлуудыг хэлэлцэв. Энэ удаагийн хуралдаанаар санхүүгийн үйлчилгээнд хиймэл оюун ухааны гүйцэтгэх үүрэг, цахим валют болон Initial Coin Offering (ICO) ба тэдгээрийн хандлага, эрсдэл болон зохицуулалт, биржээр арилжаалагдах сангийн өсөлт зэрэг сэдвүүдийн хүрээнд хаалттай хэлэлцүүлэг өрнүүлэх бол, эрсдэлтэй хөрөнгө оруулалтын зохицуулалт, зохицуулагч байгууллагуудын жижиглэн хөрөнгө оруулагчидтай харилцах үр дүнтэй хэлбэрийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын пассив болон актив стратеги, жижиг дунд үйлдвэрлэгчдийн хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломж зэргийн талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. **XC**



Зохицуулалтын мэдээ

Монгол Улсад анх удаа давхар бүртгэлтэй үнэт цаасны арилжаа эхэллээ

VI.04. Санхүүгийн зохицуулах хороо өнгөрөгч тавдугаар сарын 23-ны хуралдаанаараа Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (ERD.TSX) компанийн Монгол Улсад гаргах 4,000,000 ширхэг энгийн хувьцааг бүртгэсэн. Ингэснээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлд анх удаа дэлхийн нэр хүнд, нөлөө бүхий томоохон хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн хувьцаа давхар арилжаалагдах боломж бүрдсэн юм. Тус хувьцааны арилжааг эхлүүлж, нээлтийн цан цохих ёслолын ажиллагаа “Монголын

Хорооны дарга С.Даваасүрэн, ёслолын ажиллагааны үеэр хэлсэн үгэндээ, Монголын хөрөнгийн зах зээлд хөгжлийн түүхэн шинэ бүлэг нээгдэж байгааг онцлоод, дэлхийн стандарт шаардлагыг хангаж Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэгдсэн компани манай үнэт цаасны зах зээлд хувьцаагаа арилжаалах нь эргээд дотоодын хувьцаат компаниуд, улмаар зах зээлд эерэг нөлөө үзүүлнэ гэлээ. Мөн тэрээр, хөрөнгийн зах зээл иргэд, хөрөнгө оруулагчдад үнэт цаасны арилжаанд оролцох, бизнесийн байгууллагуудад үйл ажиллагаагаа өргөжүүлэх, засаглалаа сайжруулах, шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг босгох боломж олгодог бол төр, засагт ядуурлыг бууруулах, баялгийг зөв хуваарилах нөхцөл бололцоог бий болгож өгдгөөрөө онцлог болохыг дурдав.



хөрөнгийн бирж” ТӨХК- ийн арилжааны танхимд боллоо.

Ёслолын ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн, УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар, “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” компанийн ерөнхийлөгч Петер Акерли нар оролцож, Монгол Улсад анх удаа хийгдэж буй давхар бүртгэгдсэн хувьцааны арилжааны үйл ажиллагаанд оролцсон бүх мэргэжилтнүүд, байгууллагуудад баяр хүргэв. Торонтогийн болон Монголын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй үнэт цаас, түүний арилжаа манай улсын хөрөнгийн зах зээлийн идэвх, иргэд, хөрөнгө оруулагчдын сонирхол, оролцоог дээшлүүлээд зогсохгүй санхүүгийн салбаруудын үйл ажиллагаа, уул уурхайн компаниудын засаглалд эерэгнөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Тэрээр цааш нь хэлэхдээ, өнгөрсөн жил гаруйн хугацаанд Хороо иргэдийн идэвх, сонирхлыг татахуйц шинэ бүтээгдэхүүнийг хөрөнгийн зах зээл дээр танилцуулах чиглэлээр онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа. Цаашид ч үргэлжлүүлэн илүү идэвх чармайлттай ажиллах болно гэсэн юм.

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (ERD.TSX) компани Онтариогийн Үнэт цаасны зохицуулах хорооны шийдвэрийн дагуу 2005 оны 12 дугаар сараас Торонтогийн хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалж байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад хайгуулын дөрөв, ашиглалтын нэг тусгай зөвшөөрөлтэйгөөр уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг тус компани шинээр гаргаж буй хувьцаагаараа татан төвлөрүүлэх хөрөнгийг энэ онд хийх

хайгуулын өрөмдлөгийн ажил, мөн Монгол Улс дахь төслүүдийн эрдэс баялгийн нөөц тогтоох, техникийн судалгаа хийх ажлуудад зарцуулахаар бизнес төлөвлөгөөндөө тусгаад байгаа юм.

Энэ үеэр УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар Монголын зах зээлд хувьцаагаа давхар арилжиж буй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” компанийн хамт олонд амжилт хүсэж, бидний хамтын ажиллагаа эдийн засагт эерэг өөрчлөл авчирна гэдэгт итгэлтэй байна гэлээ. Уул уурхайн баялгаасаа хувь хүртэх, хувьцаа эзэмших боломжтой болж буй нь чухал үйл явдал болохыг сайд онцолсон бол “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” компанийн ерөнхийлөгч Петер Акерли, нягт хамтран ажилласан байгууллага, хүмүүст талархал илэрхийлж, компанийхаа 14 жилийн хугацаанд хайгуулын ажилд 50 сая гаруй ам.доллар зарцуулж, одоо үр шимийг нь хүртэх гэж байгааг хэлээд Монголын хөрөнгийн биржийн 5736 дахь арилжааг нээж цан цохилоо.

Хүртээмжтэй даатгалын хөгжлийн зураглал гаргах Үндэсний багууд дахин уулзлаа

VI.22. ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GI2/, Дэлхийн манлайллын академи /GLA/ болон Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэгч Олон Улсын байгууллага /A2II/ хамтран хэрэгжүүлж буй “Хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн олон улсын хоёр дахь удаагийн уулзалт Албани Улсын Дуррес хотноо боллоо. Эхний уулзалт энэ оны гуравдугаар сард Гана Улсад болсон юм.

Хөтөлбөрт шалгаран оролцож байгаа Монгол, Гана, Кени болон Албани улсуудын Үндэсний багийн гишүүд уулзалтад оролцож хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх, зохистой зохицуулалтын орчныг бий болгох талаар тус тус санал санаачилга, сорилт туршлагыг хэлэлцэв. Манай улсын үндэсний багийг Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга М.Өлзийбат тэргүүлж, Монголын даатгагчдын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбооны төлөөллүүдийн хамт тус уулзалтад оролцлоо.

Уулзалтаар, үндэсний багууд



хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэхэд дэмжлэг болохуйц санал, туршлагаа ярилцаж, бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах, дэвшилтэт технологи, шийдэлд суурилсан борлуулалтын сувгийг нэвтрүүлэх, төрийн зохицуулалтыг оновчтой болгох, хүртээмжтэй даатгалыг хөгжүүлэх зураглал бий болгох зэрэг олон асуудлаар харилцан суралцав. Мөн Албани Улсын даатгалын үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаатай танилцаж, мөн бизнесийн байгууллагууд, тэр дундаа жижиг, дунд бизнес, үйлдвэрлэл эрхлэгчдийн эрсдэл, бэрхшээл ямар байгаатай танилцан, судалж тэдгээрийг даатгалын арга хэрэгслээр бууруулах боломжийг эрэлхийлэн, санал солилцоо.


Уулзалтаас, хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, нөхцлийг уян хатан болгох, аргачлал, тооцооллыг боловсронгуй болгох, борлуулалтын сувгийг өргөжүүлэх шаардлагатайг онцолсны дээр иргэд, олон нийтийн даатгалын талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах нь зүйтэйг тэмдэглэв.

11, 12 дахь хөрөнгө оруулалтын сангууд байгуулагдав

V.23. Санхүүгийн зохицуулах хороо энэ сард “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Үндэсний стратегийн хөрөнгө оруулалт”, “Силк рөүд Ассет Менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Кинг Фанд” хувийн хөрөнгө оруулалтын сангуудын баримт бичгийг бүртгэж баталгаажууллаа. Эдгээр сангууд Хөрөнгө оруулалтын сангийн тухай Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдаж байгаа 6, 7 дахь хувийн хөрөнгө оруулалтын сангууд болж байна.

Манай улс хувийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг 2002 онд батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд зохицуулж байсан. Гэвч 2013 оныг хүртэл хөрөнгө оруулалтын сан сонгодог утгаараа тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үүсгэн байгуулагдаагүй. 2013 онд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталж, эрх зүйн орчин бүрдсэнээр гадаад, дотоодын иргэн аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалтын менежментийн компани байгуулах замаар хувийн хөрөнгө оруулалтын сангуудыг үүсгэн байгуулах сонирхлыг нэмэгдүүлсэн.

Хорооноос 2014 оноос 2018 оны нэгдүгээр улирал хүртэл олгосон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тусгай зөвшөөрлийн тоо, бүртгүүлсэн хувийн хөрөнгө оруулалтын сангуудын тоог



графикаар үзүүллээ. Үүсгэн байгуулагдсан хувийн хөрөнгө оруулалтын сангууд хуулийн дагуу Засгийн газрын өрийн хэрэгсэл, хаалттай хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа, үл хөдлөх эд хөрөнгө болон үл хөдлөх эд хөрөнгийг эзэмших эрхэд хөрөнгө оруулах сонирхол өндөр байна.

“Монголын компанийн засаглалын форум 2018” боллоо

VI.12. “Компаниуд засаглал сайтай байх нь зөвхөн тухайн компанийн асуудал биш юм. Компаниуд засаглалаа сайжруулснаар тэдний шийдвэр гаргах чадвар нэмэгдэж, удирдлагын мэргэшсэн баг бүрдэн, бизнесийн алсын хараагаа зөв тодорхойлж, компанийн үнэт зүйл, компанийн соёлыг цогцлоож, улмаар нөөц боломжоо бүрэн ашиглаж боломжит хамгийн их баялгийг бүтээж чаддаг. Энэ нь улс орны эдийн засгийн багтаамжийг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжиж, өрсөлдөх чадварыг сайжруулж, эрсдэл хямралд өртөх магадлалыг бууруулахын зэрэгцээ ажилгүйдэл, ядуурал зэрэг нийгмийн асуудлуудыг шийдэхэд ч эерэгээр нөлөөлнө”.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн “Монголын компанийн засаглалын форум 2018”-ыг нээхдээ ийн онцолсон юм. Тэрээр, Компанийн засаглалын кодекс болон холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд Хороо энэ асуудалд онцгой анхаарал хандуулж байгааг тэмдэглэн, хөрөнгийн зах зээл мэдэгдэхүйц сэргэж, үнэт цаасаа олон нийтэд санал болгож, хөрөнгө оруулалт татах сонирхолтой компаниуд улам нэмэгдэж байгаа энэ үед хувьцаа гаргагчдад засаглалын шаардлагуудыг өндрөөр тавьж байгаагаа дуулгав.

Хороо болон Дэлхийн банкны Олон Улсын санхүүгийн корпорац (IFC), “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-ын хамтран зохион байгуулсан тус форум нь энэ жил 10 дахь удаагаа болж буй юм. Чуулганд Олон Улсын санхүүгийн корпорацийн суурин төлөөлөгч Туен Д.Нгуен, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга Р.Амаржаргал нар үг хэлж, Олон Улсын санхүүгийн корпорацийн Ази, Номхон далайн бүсийн компанийн засаглалын хөтөлбөр хариуцсан тэргүүлэх мэргэжилтэн Ж.Крис Разук үндсэн илтгэл тавив. Ноён Ж.Крис Разук илтгэлдээ компанийн засаглалын асуудлыг хөрөнгө оруулагчийн байр сууринаас өгүүлж, Олон Улсын санхүүгийн корпорацийн өөрийн хөрөнгө оруулалтын багц дахь компаниудын засаглалын судалгаанд тулгуурлан ярьсан нь ихээхэн сонирхол татахуйц болсон юм.

Чуулган “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нь”, “Компанийн засаглалыг зохицуулагч байгууллагын өнцгөөс харахад” гэсэн гол хэлэлцүүлгүүдээр өрнөсөн юм. Хоёр дахь хэлэлцүүлэгт Хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Лхагвасүрэн панелистаар оролцож, банкнаас бусад санхүүгийн



салбарууд, тэр дундаа нээлттэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр явуулж ирсэн үйл ажиллагаа, үр дүн болон цаашид баримтлах чиглэлийн талаар дэлгэрэнгүй хариулт өгөв.

AFI бүс нутгийн тав дахь зөвлөлийг шинээр байгуулахаар боллоо

VI.08. Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн Оросын Холбооны Улсын Санкт Петербург хотноо хуралдсан “Олон улсын санхүүгийн XXVII чуулган”-д оролцлоо. Чуулганаар банк,

Африкийн, Номхон далайн арлуудын гэсэн бүс нутгийн дөрвөн зөвлөлтэйгөөр ажиллаж байна. Зөвлөлүүд бүс нутгийнхаа санхүүгийн хүртээмжтэй холбоотой асуудал, сорилтуудад түлхүү анхаарал тавьж, хамтран ажиллаж шийдвэр гаргадаг. Ингэснээр бүс нутгийн онцлогийг санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн зорилготой уялдуулах, гишүүддээ илүү зохистой, ач холбогдолтой бодлого боловсруулах нөхцлийг бүрдүүлдэг.

Нийгэмлэгийн өндөр түвшний уулзалтаар шинээр байгуулах Зүүн Европ, Төв Азийн бүсийн зөвлөлийн дүрэм, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцлээ. Хорооны дарга С.Даваасүрэн энэ үеэр санхүүгийн зах зээлийн хөгжилд хөрөнгө оруулагчдын

гэрээнд Хорооны Даатгалын газрын дарга М.Өлзийбат Монголын банкуудын холбооны дэд ерөнхийлөгч Д.Баярсайхан, Монголын даатгалын холбооны Удирдах зөвлөлийн дарга П.Эрдэнэбаатар, Монголын даатгалын зуучлагчдын холбооны ерөнхийлөгч Ц.Төрболд нар гарын үсэг зурав.



Хороо өнөөдрийн байдлаар үнэт цаасны, даатгалын, банк бус санхүүгийн болон хадгаламж зээлийн хоршооны салбарын нийт 2100 гаруй санхүүгийн байгууллага, хуулийн этгээдэд хяналт, зохицуулалт хийж ажилладаг. Зохицуулалттай этгээдүүддээ хүрч ажиллахад салбар тус бүрийн мэргэжлийн холбоод, хамтын байгууллагууд ихээхэн дэм болдгийг гэрээнд гарын үсэг зурах ёслолын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Ариунаа онцоллоо.



даатгал, тэтгэвэрийн сан, бичил санхүү, хөрөнгийн зах зээлийн тогтвортой өсөлтийг хангах асуудлыг хөндөн ярилцаж, тулгамдаж буй бэрхшээлийг шийдвэрлэх гарц, хөгжлийн стратегийн талаар өргөн хүрээний хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага өрнөв.

Чуулганы үеэр Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс Зүүн Европ, Төв Азийн санхүүгийн хүртээмжийн зөвлөлийг байгуулахтай холбоотой асуудлаар өндөр түвшний уулзалт зохион байгуулсан юм. Уулзалтад манай улсын болон ОХУ, Киргизстан, Армен, Беларусь, Казакстан Улсын Төв банк, санхүүгийн зохицуулах байгууллагын тэргүүн, тэргүүн дэд ерөнхийлөгч нар, мөн Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн гүйцэтгэх удирдлага оролцлоо.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг өнөөдрийн байдлаар Африкийн, Өмнөд Америк болон Карибын тэнгисийн арлуудын, Ойрхи Дорнод болон Хойд

итгэл, санхүүгийн боловсрол чухал бөгөөд үүний зэрэгцээ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэн хөгжүүлэх нь нэн шаардлагатай хүчин зүйл болж буйг онцолсон юм. Ингэснээр Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, цахим санхүүгийн үйлчилгээ буюу финтекийг хөгжүүлэх гэсэн хэсэгтэйгээр батлахаар тогтов.

Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа

VI.15. Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкуудын холбоо болон Даатгалын салбарын мэргэжлийн холбоотой Хамтын ажиллагааны гэрээ байгууллаа. Гэрээ байгуулах ёслолын ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн оролцож,



Тэрээр санхүүгийн салбар гурван тулгууртай бөгөөд үнэт цаасны, даатгалын болон банк, санхүүгийн салбарууд жигд хөгжиж, тэгш тулах учиртайг онцлоод, энэхүү тулгууруудын нэг даатгалын салбарт сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц



өсөлт гарч, цаашид улам өргөжин хөгжих орон зай байгааг харуулж буйг болон үүнд зохицуулагч байгууллага, мэргэжлийн холбоодын нягт хамтын ажиллагаа чухал үүрэгтэйг дурдлаа. Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт даатгалын зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр тодорхой зорилго, зорилт туссан нь төрийн зохицуулагч байгууллагын үйл ажиллагааны чиглэл болж буйг Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Ариунаа тэмдэглэж, эдгээрийг хэрэгжүүлэхэд зах зээлд оролцогчид, тэдгээрийн боловсон хүчнийг чадавхжуулах, мэргэжлийн холбоод институтыг бэхжүүлэх нь нэн чухал гэлээ.

Хороо мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах хүрээндээ даатгалын зах зээлд оролцогчид, тэдгээрийн боловсон хүчнийг чадавхжуулах үүднээс сургалтын үйл ажиллагааг түлхүү явуулахаар гэрээнд тусгаад байгаа юм. Салбарын боловсон хүчнүүдэд зориулсан даатгалын мэргэжлийн оролцогчдод эрх олгох болон мэргэшүүлэх сургалтыг Холбоод мэргэжлийн түвшинд, чанартай зохион байгуулах, Хороо хяналт тавих болон холбогдох чиг үүргээ хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлж ажиллах харилцааг гэрээнд нарийвчлан заажээ.

Түүнчлэн Хороо болон мэргэжлийн холбоод хамтын ажиллагааныхаа хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ харилцан санал солилцож, нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллах юм. Мөн Хороо хамтын ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, даатгалын салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээ тогтоох бол Холбоод зохих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах талаар санал, санаачлагатай, үр өгөөжтэй ажиллахаар харилцан үүрэг хүлээсэн байна.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн асуудлаар ҮЦХОУБ зөвлөмж гаргахаар боллоо

V.07-11. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн Будапешт хотноо хуралдсан Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (ҮЦХОУБ, IOSCO)-ын 43 дахь удаагийн чуулганд оролцлоо. Энэ жилийн чуулган санхүү, хөрөнгийн зах зээлд сүүлийн жилүүдэд хүч түрэн орж ирж буй цахим валют, цахим санхүүгийн хэрэгслийн хөгжлийн хандлага, түүний эрсдэл, зохицуулалт болон мэдээллийн технологи, хиймэл оюун ухаанд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар



онцгойлон авч үзэж байгаагаараа онцлог болов.

Хорооны дарга С.Даваасүрэн чуулганы үеэр ҮЦХОУБ-ын Ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралдаан, Ази-Номхон далайн бүсийн болон Хөгжиж буй зах зээлийн хороодын хуралдаан, мөн “Санхүүгийн үйлчилгээний ирээдүй: Хиймэл оюун ухаан”, “Крипто валют ба цахим мөнгө нийтэд санал болгох нь: Зах зээлийн хандлага, эрсдэл, зохицуулалтын арга хэмжээ”, “Биржээр арилжаалдаг сан: Санхүүгийн хэрэгсэл” сэдэвт салбар хуралдаанд оролцлоо.

Тэрээр чуулганы үеэр ҮЦХОУБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Пол Эндрюс, дэд дарга Тажиндер Сингх, Хөгжиж буй зах зээлийн комиссын дарга Ралука Теркочи нартай уулзлаа. Уулзалтаар хөрөнгийн зах зээлийн хөгжлийн хандлага, ялангуяа энэ зах зээлд нэвтэрч буй финтекийн шийдэл, шинэтгэл болон хөгжүүлэлтийн хэтийн төлөв, санхүүгийн зах зээлүүдийн нэгдэл интеграцийн талаар дэлгэрэнгүй ярилцав.

ҮЦХОУБ-ын удирдлагуудад тэрээр Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн талаар танилцуулж, хууль эрхзүйн орчны үнэлгээ хийж, олон улсын стандартад нийцүүлэх шаардлагуудыг тодорхойлж, эрхзүйн орчныг сайжруулах бодлогын зөвлөмж гаргуулахаар тохиролцлоо.

Даатгалын зах зээлд мөрдөж буй зарим журам, заавар, стандартыг шинэчлэн баталлаа

VI.04. Шинээр мөрдөгдөж буй Захиргааны ерөнхий хууль болон Зөрчлийн хуулиудтай уялдуулах шаардлагын дагуу Хороо журам, дүрмүүдээ шинэчлэх ажлыг хийж байна. Үүний хүрээнд “Сайн

дурын даатгалын хэлбэр”, “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”, “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын мэдүүлгийн маягт, гэрээний стандарт, загвар” болон “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам”, “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”, “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”, “Жолоочийн даатгалын сангийн данс байршуулах, санхүүжилтийг төвлөрүүлэх, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ыг тус тус шинэчлэн баталлаа.

Сайн дурын даатгалын хэлбэрүүдээс факультатив хувь тэнцүүлсэн оролцооны давхар даатгал, гэрээт хувь тэнцүүлсэн оролцооны даатгалын төрлүүдийг хасаж, орон сууцны ипотекийн зээлийн даатгалыг холбогдох хэлбэрүүдийн агуулгад нэмлээ. “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т, бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх, мэдлэг, туршлага, ур чадвар хангалттай байх, санхүүгийн байдал хэвийн байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх гэсэн үндсэн шалгууруудыг тусгав. “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-д Хорооны 2012 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-ыг нэгтгэв. Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжид зарим итгэлцүүрийг тооцдоггүй байсныг өөрчилж 9 итгэлцүүрээр бүрэн тооцох болголоо. Мөн И2 итгэлцүүрийг даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах болгов.

Компаниуд ногдол ашиг тараадаг болоход хувьцаа эзэмшигчдийн санаачилга дутаад байна

Эхлэл 1-р нүүрт

-Үйл ажиллагаа явуулдаг компаниудын 2.5 хувь нь буюу зургаахан компани 2013-2018 оны хооронд буюу сүүлийн зургаан жил дараалан ногдол ашиг тараасан. Сүүлийн гурван жилд ногдол ашгаа тараасан гэвэл таван компани нэмэгдэнэ.

-Маш бага тоо байна. Ногдол ашгаа тараадаг компаниудыг нэрлээч?

-СЗХ бол төрийн байгууллага. Сайн, муу ямар ч жишээнд компаниудыг нэр зааж дурдах нь бизнест нөлөөлөх эрсдэлтэй. Төрийн байгууллагын хувьд ёс зүй, этик талаасаа шууд нэр дурдах нь зохимжтой биш л дээ.

-Биржид бүртгэлтэй ТОП 10 гэхэд л хувьцааных нь маш цөөн хувь иргэдэд байдаг. Том компаниуд дэргэдээ трейдинг компани байгуулж орлогоо хийгээд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг тараадаггүй. СЗХ үүнийг нь бүр өөгшүүлчихсэн гэсэн шүүмжлэлд та ямар хариу өгөх вэ?

-Энэ асуудалд хоёр байр сууринаас хандаж байгаа. Нэгдүгээрт ерээд оноос хойш өнөөг хүртэл үндэсний томоохон компанийнхаа хувьцааг эзэмшиж өдий дайтай ажиллуулж яваа хүмүүст баярлах ёстой. Яг тэдэн шиг ажиллалчаар үндэсний хэд хэдэн том компани байсан ч дампуурсан жишээ өчнөөн гэдгийг та ч мэднэ. Маш олон жижиг хувьцаа эзэмшигчид нь төмөр, хадаас, модыг нь салгаж авсаар байгаад юу ч үгүй болгосон харамсалтай түүх бий. Хувьцааг хэт төвлөрүүлж авчихаад ногдол ашиг бага тарааж хувьцаа эзэмшигчдийг хохироосон асуудал өнөөг хүртэл яригдсаар байгаа нь бодитой үнэн. СЗХ-ны хувьд энэ асуудлыг аль болох цэгцлэх гэж хичээж байна. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг бол анхаарахгүй орхиж болохгүй асуудал. Хувьцаат компаниуд жил бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж ногдол ашгаа тараах ёстой. СЗХ 2015 оноос хойш энэ чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

-Та түрүүн төрийн байгууллага гэдэг утгаараа компаниудыг нэр дурдахад хэцүү гэж ярьсан. Гэхдээ олонд ил өчнөөн асуудал бий. Жишээ нь Улсын их дэлгүүр байна. Түрээсээр асар их ашиг олж байж ногдол ашгаа өгдөггүй гэсэн



Б.Лхагвасүрэн

"...Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг бол анхаарахгүй орхиж болохгүй асуудал..."

гомдлыг хувьцаа эзэмшигчид нь тавьдаг. Ийм барим тавим асуудлыг шийдэх талд хэр анхаарч ажиллаж байгаа вэ?

-Өнгөрсөн жил гэхэд УИД-тэй нэлээд хэлэлцээр хийсэн. Хувьцаа эзэмшигчдийг хохироохгүй, ногдол ашгаа тарааж байх талаас нь зөвлөмжүүд өгсөн байгаа. Шийдвэрлэх хэмжээнд хүрсэн гэж бодож байна.

-Хэр өндөр ашигтайг нь шууд харчихаж болохоор ийм газар өдийг хүртэл хувьцаа эзэмшигчдэдээ ашиг хуваах тал дээр асуудал үүсгэсээр ирсэнгэхэд итгэмгүй санагддаг. Танд арай л санагддаггүй юу?

-Санагддаг. Гэхдээ гээндээ ч бий, гоондоо ч бий гэдэг шиг асуудлууд ч анзаарагддаг. Хувьцаа эзэмшигчид нь өөрсдөө гүйж очоод "Би танай түрээслэгч больё. Хөнгөлж туслаач" гэж хандаад яриа хэлэлцээр хийчихдэг, дараа нь үүссэн жижиг сажиг асуудлаас үүдэж гомдол гаргадаг гэх мэт асуудал олон юм билээ. Энэ тохиолдолд иргэн хооронд асуудал үүсч байгаа биз. Тэгэхээр аливаа асуудлыг шууд харж, бүхнийг СЗХ мэддэг гэж хандах нь нэг талдаа өрөөсгөл хэрэг болчихож байгаа юм. Муу л бол хойд талын хар овоохой гэдэг шиг сэтгэхүй иргэдэд суучихаад байна л даа. СЗХ юм чинь санхүүтэй холбоотой бүх асуудлыг зохицуулна гэж боддог. Гэвч бүх юм хууль дүрэм заавартай. Энэ утгаараа СЗХ ирсэн гомдол саналыг журмынх нь дагуу л шийддэг газар. Түүнээс биш аливаа аж ахуйн нэгж, иргэний бүх асуудал руу шууд дайраад ороод байх боломж ямар ч субьектэд байхгүй. Гэхдээ нэг зэрэг мэссэж бий. Компаниуд хөрөнгийн зах зээл дээр нээлттэй ил тод сайн засаглалтай байвал хувьцаа гаргаж хямд санхүүжилт татах бололцоотой. Нээлттэй компанид л хөрөнгө оруулагчид буюу иргэд мөнгөө итгэж өгнө. Түүнээс биш бүх юмаа нуучихаад би 90 хувьтай, чи арван хувьтай бай гэвэл хэн ч хөрөнгө оруулахгүй. Харин компанийнхаа нийт

хувьцааны 30 хувийг нийтэд арилжаалаад явцын дунд ахиад нэмж гаргая гэвэл хүмүүс сонирхоно. Энэ тохиолдолд "Над шиг олон хүн энэ компанийн хувьцаа эзэмшигч юм байна. Тийм учраас би хадгаламжин дахь мөнгөө ийш нь оруулъя. Энэ компани олон жилийн дараа өгөөж ашигтай ажиллаад эхлэхээр үр хүүхэд минь өндөр орлоготой амьдраг" гэсэн бодолтой хүмүүс олширно.

-Компаниудын хувьцаа эзэмшигчдээсээ ашгаа бултуулдаг "трэйдиг"-үүдийг өөрчилнө гэхээр тусдаа компанийн асуудал учраас мэдээж хэцүү. Гэхдээ хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байгаа гэдэг утгаар СЗХ ямар нэг шийдэл, зөвлөмж өгөх ёстой байх аа?

-Мэдээж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн асуудал яах аргагүй мөн. Энд ганц бодитой, хэрэгжиж болох гарц бий. Хувьцаа эзэмшигчид өөрсдөө санаачлагатай байх хэрэгтэй. Урт хугацаанд тухайн компанийн хувьцаа эзэмшигч байа гэж бодож байгаа бол жилд ганц удаа болдог хуралд нь маш идэвхтэй оролцох ёстой.

-Компаниуд хурлынхаа зарыг идэвхтэйгээр сурталчилж байж л хувьцаа эзэмшигчдэд хүрнэ. Гэтэл сонини жижигхэн зайд хүн харахааргүй газар тавьчихдаг шүү дээ?

-Яг зөв асуудал хөндлөө. Зарлаад байгаа хэлбэр, тавьдаг санхүүгийн тайлан нь бэлгэ тэмдэг төдий болсон нь үнэн. Наад асуудлыг чинь хорооны удирдлагын хэмжээнд өнгөрсөн жилийн эцсээр хөндөж яриад мэдэгдэл хүргүүлсэн.

-Иргэдийн хувьд цөөхөн хувьцаатай болохоор хувьцаа эзэмшигчдийн хурлыг зорьж очихгүй байгаа тал бас анзаарагддаг...?

-Цөөхөн хувь эзэмшдэг болохоор ийм харилцаа үүсдэггүй тал байгаа нь мөн л үнэн. Тийм учраас СЗХ-ноос компаниудад дор хаяж 30 хувиа арилжаал гэсэн шаардлага тавьж байгаа.

-Тэгэхээр шинээр хувьцаагаа арилжаалж байгаа компаниуд дор хаяж 30 хувийнхаа хувьцааг арилжаалах нь гэж ойлгож болох уу?

-Тэгж ойлгож болно. Бид цаашдаа ч энэ чигээ барина. Хамгийн багадаа 30 хувийн хувьцаагаа санал болго, тэгж байж хөрөнгө оруулагчдын эрх ашиг

хамгаалагдаж, компани нээлттэй ил тод болно гэсэн бодлогыг хорооны зүгээс барьж байна.

-Сүүлд IPO гаргасан “Монгол базальт” дээр гэхэд л хувьцааных нь үнэ доошилчихлоо, зах зээлд үнийн хөөсрөл үүсгэж, хөрөнгө оруулагчдыг хохироох нь гэх мэтээр тайлбарлах боллоо. Энэ хэр бодитой тайлбар вэ?

-Тэгж бодохгүй байна. Олон улсад тухайн улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг ДНБ-нд хэдэн хувь эзэлж байгаагаар нь хэмждэг. Монгол улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өнгөрсөн жилийн сүүлээр л ДНБ-ий есөн хувийг эзэлсэн. Гэтэл хөрөнгийн зах зээл нь хөгжсөн улсуудын хувьд энэ харьцаа тэс өөр. Хөрөнгийн зах зээлийнх нь үнэлгээ ДНБ-ээс нь хэд дахин илүү үнэлгээтэй байдаг. Тэгэхээр хөөс гарч, хохирол хүлээх нь гэх мэт яриа бодитой биш мэдээлэл.

-Гадаадын нэг хөрөнгө оруулагчтай ярилцаж байхад “Танай хөрөнгийн зах зээл богино зайны, мэргэжлийн биш тоглогч олонтой” гэж байсан. Богино хугацаанд өндөр ашиг олох гэсэн хүсэлтэй хүмүүс ийм яриа гаргаад байна уу?

-Тантай санал нэг байна. Сүүлийн үед шинээр гарч байгаа хувьцаан дээр богино хугацаанд тоглолт хийх явдал их ажиглагдаж байна. Богино зайны тоглогчдын хувьд тэгж хэлэх эрхгүй хүмүүс. Өөрсдөө дүрмээ мэдээд

Хамгийн багадаа 30 хувийн хувьцаагаа санал болго, тэгж байж хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдана гэсэн бодлогыг Хороо барьж байна.

богино зайнд тоглож байж олон нийтэд нөлөөлөхийн тулд худлаа сенсация болгохгүй. Зах зээлд сайнаар нөлөөлөх хандлага лав биш. Гэхдээ бид анализ хийж үзнэ. Ер нь хөрөнгийн зах зээлд цаашдаа өчнөөн боломж бий. Хүний хэрэгцээ шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниуд хөрөнгийн зах зээлээс хямд эх үүсвэр босгоосой гэж хүсэж байна. Хувьцааны үнийн өсөлт, уналт байдаг л асуудал. Юунаас болж өсч унаад байна вэ гэдгийг судалж үзэх ёстой. Үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх гэж мөнгө босгосон компанийн хувьд өгөөжөө харахын тулд дор хаяж нэг жил, түүнээс ч олон жил шаардагдана.

-СЗХ бидний төлөө хөдөлж өгөхгүй байна гэсэн шүүмжлэл давтамжтай

сонсогддог. Энэ хэр бодитой шүүмжлэл бол. Хууль эрх зүйн орчноос болоод яах аргагүй хашигдаад байна уу?

-Би энэ албандаа хоёр жил ажиллаж байна. Анх ажлаа эхлэхэд “Хууль дүрэм нь хэрэг алга, боож хаагаад хэцүү байна” гэсэн хүмүүс их оржирдэг байсан. Үнэхээр тийм юм болов уу гээд судлахаар хэцүү юм байдаггүй. Тухайн компани хууль эрх зүйн орчноо бүрэн дүүрэн бүтэн нэг эргээгүй гэсэн шалтгааныг л олж хардаг. Хуулийг дуустал нь ашиглаад, ургаж гарсан асуудал дээр нь дөрөөлөөд санаа оноо гаргавал өөр шүү дээ. Тэгэхгүйгээр дунд нь нэг жижиг уул тааралдангуут хормойгоо шуугаад байвал хэцүү.

-Тэгвэл СЗХ бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллахад хууль зүйн талаас ямар ч бэрхшээл, асуудал байхгүй гэж ойлгож болох уу?

-Би тэгж хэлэх гээгүй. Асуудал мэдээж бий. Хамгийн гол нь тухайн асуудлыг туршиж үзээд гарсан кейс дээр нь ийм байна гэж ярих хэрэгтэй. Ихэнх тохиолдолд жижиг сажиг асуудлаа давж чадаагүйнхээ төлөө бурууг гаднаас хайгаад байгаа анзаарагддаг. Тэр буруутан нь эзэн биегүй хууль болчихоод байна л даа.

-Гэхдээ СЗХ ямар нэг бодлогын юм гаргадаггүй, бүртгэсэн, зөвшөөрсөн гэх мэтээс хэтэрдэггүй гэсэн шүүмжлэл ортой л сонсогддог. Хууль зүйн талаас нь харахад хүчтэй ажиллаж болохоор газар гэж ойлголоо, зөв үү?

-Хууль зүйн хүрээнд хашигдсан боогдсон зүйл байхгүй. Хууль талаасаа эрхээ хэрэгжүүлээд ажиллах боломжтой газар гэж хардаг.

-Тэгвэл хүчгүй байлгах сонирхол байдаг юм биш үү?

-Тийм гэж шууд хэлэх аргагүй. Ор тас үгүйсгэх ч аргагүй. Зарим талаар санал нийлж байна.

-СЗХ хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулагчдын талд бүрэн ажиллаж шийдвэр гаргаж чадаж байгаа юу?

-Хамгийн түрүүнд хөрөнгө оруулагчаа буюу иргэдээ боддог нь бидний баримталдаг гол зарчим. Тэр утгаараа хувьцаагаа арилжаалах гэж хандсан компаниудад “Хөрөнгө оруулагч танд яагаад итгэх ёстой вэ” гэж асуудаг, тэр үүднээс танилцуулгыг нь нарийн нягталж судалсны эцэст шийдвэрээ гаргадаг. Хөрөнгийн зах зээл дээрээс олон нийтээс мөнгө татаж болох нь гэсэн хандлага илэрхий ажиглагдаж байна. Нөгөө талаас хөрөнгөө оруулаад өгөөж хүртэх боломж ч харагдаж байгаа.СЗХ-ны Үнэт цаасны газрын хувьд хүмүүсийн итгэл сэргэсэн нь сайшаалтай ч бодит

байдал дээр чанарын өсөлт биш гэж дүгнэж байгаа. Юуны түрүүнд хувьцааны хөрвөх чадвар чухал. Компанийн хэдэн хувь нь олон нийтэд арилжаалагдаж байна вэ гэдэг маш чухал асуудал.

-Танайхаас IPO гаргах гэж байгаа компаниудад ямар шалгуур тавьдаг вэ?

-2013 онд шинэчлэн батлагдсан, 2014 оноос дагаж мөрдөгдөж эхэлсэн Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар IPO хийх гэж байгаа компани үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтээ Хороо болон биржид нэгэн зэрэг гаргах болох ба СЗХ-ны Үнэт цаасыг бүртгэх тухай журмын дагуу нарийвчилсан шалгуур, шаардлага тавигдана. Хорооны журмаар эхлээд биржүүдэд үнэт цаасаа бүртгүүлж, биржийн зүгээс болж байна гэвэл манайх руу дүгнэлтээ ирүүлдэг. Тэр үед нь бид компанийн танилцуулгыг үзэж эхэлдэг. 2013 оноос өмнө манайх эхлээд танилцдаг байсан юм. Энгийнээр хэлбэл бирж бол дэлгүүр. Ирсэн барааг зарахад анхаардаг газар гэсэн үг. Эцсийн хариуцлагыг бирж биш үнэт цаасны танилцуулгыг хийсэн андеррайтер, адуит, хууль, үнэлгээний компани, СЗХ хариуцдаг гэдэг утгаараа бараа хэр чанартайг СЗХ шийддэг.

-Тэгвэл танайхаар эхэлж явдаг зарчим нь зөв байж дээ?

-Уг нь тийм. Гэхдээ эцсийн шийдвэрийг манайх гаргаж байгаа нь хэвээрээ. Сая гэхэд хоёр ч компани биржээс зөвшөөрөл аваад ирсэн. Материалыг нь үзэхээр нэг нь компанийн нийт хувьцааныхаа 15 хувийг гаргана гэсэн байсан л даа. Нийтэд 25, 30 түүнээс дээш хувиа санал болгож байж компанийн засаглалын нээлттэй, ил тод байдал сайжирдаг гэсэн олон улсын байгууллагын зөвлөмж бий. Бид энэ мэт үндэслэл хэлж буцаасан. Гурван сарын дараа бүх материалаа шинэчлээд 30 хувиа зарья гээд орж ирэх жишээний.

-Хувьцаа худалдаж авсан хөрөнгө оруулагч хохирвол яах вэ. IPO шинээр гаргасан компаниуд Хөрөнгийн зах зээл дээр байдаг компаниуд шиг дэргэдээ трейдинг компани байгуулаад хамаг ашгаа хийгээд явах эрсдэл бий юу?

-Шинээр IPO гаргаж байгаа компаниуд явуулах үйл ажиллагаа, олох ашиг, хүртээх ногдол ашиг гэх мэт нарийн тоонуудыг хугацаатай нь товлосон бизнес төлөвлөгөөтэй орж ирдэг. Манайхаас тэр бүхэнтэй нь танилцаад арилжаалах зөвшөөрөл өглөө гээд тогтоол гаргадаг юм. Тэр тогтоол дээр бүгдийг нь нэг бүрчлэн үүрэгжүүлж, хүлээх хариуцлагуудыг нь зааж өгч байгаа.


**Ярилцсан Ц.Баасансүрэн
(Өдрийн сонин)**

Зөвшөөрлийн цахим системийг нэвтрүүлж эхэллээ

Санхүүгийн зохицуулах хороо төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох, үйлчилгээ авахтай холбоотой зардлыг бууруулах, цаг хугацаа хэмнэх, ил тод байдлыг бий болгох зорилгоор зөвшөөрлийн цахим системийг нэвтрүүлж эхэллээ.

Цахим системээр эхний ээлжинд банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын тусгай зөвшөөрлийн хүсэлт, материалыг хүлээн авч байна. Нэгдсэн мэдээллийн сан бий болгох цогц ажлын хүрээнд хөгжүүлж буй зөвшөөрлийн цахим системийг нэвтрүүлэхтэй холбоотой дагалдах ажлууд бүрэн хийгдсэний дараа Хорооны зохицуулалтад буй бусад санхүүгийн салбарууд буюу үнэт цаасны, даатгалын болон хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх ажлыг цахимжуулах юм.

Тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргагч эхний ээлжинд биеэр ирж бүртгэлтэй байгууллагын цахим шуудангийн хаяг, хариуцсан ажилтны овог нэр, регистрийн дугаар зэргийг Хороонд бүртгүүлнэ. Ингэхдээ тухайн байгууллагыг төлөөлж буй нотлох баримт бичгийг хавсаргах шаардлагатай. Үүний дараа хүсэлт гаргагч Хорооны www.frc.gov.mn веб сайтын нүүр хуудасны “Зөвшөөрлийн цахим систем” цэсээр дамжин <https://license.frc.mn> хуудсанд нэвтэрч, хүсэлтээ гарган, материалаа бүрдүүлэх боломжтой болох юм. Цахим системд хүсэлт гаргахад шаардлагатай мэдээллүүд, холбогдох журам, зааврууд байх бөгөөд хүсэлт гаргагч өөрийн асуудлыг хяналт, шийдвэрлэлтийн аль түвшинд явж буйг системээс шууд харах боломжтой. **ХС**



Хөрөнгө бий болгох



Г.Мөнхтүвшин

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын мэргэжилтэн

Монгол Улсад анхны үнэт цаасны зах зээлийн тухай хууль 1994 онд батлагдаж, улмаар үнэт цаасны зах зээлд хяналт тавих, төрийн зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх Үнэт цаасны хороо байгуулагдсан. 2002 онд үнэт цаасны зах зээлийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсан ба санхүүгийн зах зээлд оролцох хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэх болсонтой холбоотойгоор санхүүгийн зах зээлд нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгох зайлшгүй шаардлага үүссэн.

Улсын Их Хурлаас 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд дээрх хуулийн шинэчилсэн найруулга нь олон улсын стандартад нийцсэн, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалтыг агуулснаар онцлогтой болсон. Манай улсын санхүүгийн зах зээлийн банк давамгайлсан тогтолцоотой байгаа өнөөгийн нөхцөлд үнэт цаасны зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх оролцоог нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувийг өсгөхөд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах санг бий болгох зайлшгүй шаардлагатай бөгөөд уг салбарын хөгжлийг олон улсын түвшинд хүргэхэд зохицуулалт, хяналтын орчноос гадна тэдний эрх ашгийн хамгааллын тогтолцоог бүрдүүлэх нь чухал.

Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 11 дүгээр сард Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг, 2006 оны 45 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийг тус тус баталж, Хорооны бүрэн эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны хамрах хүрээг хуульчлан тогтоосноор банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллага байгуулагдсан юм. Хувьцаа зөвшөөрөлгүй зарсан тухай иргэдээс ирсэн өргөдлүүдийн хувьд арилжаа нь ихэвчлэн 2009 оноос өмнө хийгдсэн байх бөгөөд 62% нь 1996-2002 оны хооронд хийгдсэн арилжаа

оруулагчдын эрх ашгийг хамгаалах сан хэрэгцээ, шаардлага

байна. Иймд хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сан буюу брокер, дилерийн компаниудын гаргасан ёс зүйгүй үйлдэл, буруутай үйл ажиллагаанаас үүдэн хөрөнгө оруулагчдад учирсан хохирлыг барагдуулах санг байгуулах зайлшгүй шаардлага үүсч байна.

Орчин үед хөрөнгийн зах зээл нь улам бүр глобалчлагдах чиг хандлагатай болж байна. Иймд олон улсын хэмжээнд мөрдөгдөж буй нийтлэг стандарт, хэм хэмжээг судалж, хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчны суурь ойлголт хэлбэрээр ашиглах нь Монгол улсыг дэлхийн санхүүгийн зах зээлд гарахад ихээхэн дэмжлэг болох юм. Олон улсын хэмжээнд Үнэт Цаасны Хороодын Олон Улсын Байгууллага /IOSCO/-аас 2003 онд шинэчлэн баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын зорилго ба зарчим” /Objectives and Principles of Securities Regulation/ хэмээх баримт бичигт үнэт цаасны зохицуулалттай холбоотой үндсэн гурван зорилго тусгагдсан байдаг бөгөөд үүний нэг нь хөрөнгө оруулагчдын эрх

чухал нөлөө үзүүлнэ.

Хөрөнгийн зах зээл хөгжсөн улс орнуудад хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сан /ХОЭАХС/ байгуулах нийтлэг хандлага байдаг. Олон улсад хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах санг тухайн улсын санхүүгийн салбарт хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, эсхүл хөрөнгийн биржийн дэргэд байгуулсан байдаг. Хөрөнгө оруулагч нь харилцагч байгууллагын буруутай үйлдлээс шалтгаалан хохирол хүлээсэн тохиолдолд дээрх хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах санд хандан, хохирлоо уг сангаас барагдуулдаг байна. Мөн түүнчлэн хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар, зөвшөөрөлгүй ашиглаж, хөрөнгө оруулагчдад хохирол учруулсан үнэт цаасны компани нь санхүүгийн чадваргүй болсны улмаас харилцагчийн хөрөнгийг буцаан олгох боломжгүй болсон тохиолдолд сангаас тодорхой хэмжээнд

хөрөнгө оруулагчдад нөхөн олговор олгодог. ХОЭАХС-ийн хөрөнгийг гишүүдийн үйл ажиллагааны цар хүрээ, чиглэл зэргээс хамааруулан жил бүр санд оруулах хураамжийн орлогоос бүрдүүлдэг. Тус сангийн гишүүд нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэгч банк, брокер, хөрөнгө оруулалтын менежментийн компани зэрэг байна. ХОЭАХС-д төвлөрүүлэх доод хэмжээг улс бүр харилцан адилгүй байхаар тогтоодог ба уг санг үүсгэн байгуулах, хяналт тавих эрх бүхий этгээд нь мөн өөрсдийн хууль, журмаар ялгаатай байхаар зохицуулагддаг байна.

Тус сан нь гишүүн үнэт цаасны компаниудын төлөөлөгч, тэдгээрээс сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал зэрэгтэй байх ба эдгээр этгээдүүд нь сангийн удирдлага, үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Мөн сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргахдаа санг зохицуулдаг хууль буюу санхүүгийн хэрэгсэл болон арилжааны тухай хууль, хөрөнгө оруулагчдын нөхөн олговрын тухай хуульд заасны дагуу зохицуулалт тавих үүрэг бүхий байгууллагаас өгсөн чиглэлийг тус тус баримталдаг байна.

Хөрөнгө оруулагч, ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол илүү хөндөгдөж, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламж, бүртгэлийн бие даасан тогтолцоог бий болгосон боловч түүнтэй холбоотой зарим харилцаанд эрх зүйн зохицуулалт дутагдсаар байна. Үнэт цаасны компаниудын гаргасан хууль бус үйлдлээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах, улмаар үнэт цаасны компаниудтай холбогдолтой харилцагчдын гаргасан нэхэмжлэлд нөхөн олговор олгох зорилгоор хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах санг байгуулах шаардлагатай юм.

Тус сан нь системийн эрсдэлийг бууруулах, зах зээлийн үнэнч шударга, ил тод бүтцийг бүрдүүлэх мөн хөрөнгийн зах зээлд итгэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх юм. Хөрөнгө оруулагчийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэнээр хөрөнгө оруулагчдын хөрөнгө найдвартай хамгаалагдаж, харилцагч ҮЦК-иуд төлбөрийн чадваргүй болсноос үүдэн хөрөнгөө алдах эрсдэлийг бууруулж, нөхөн олговрын систем бүрдэнэ. **ХС**



ашгийг хамгаалах асуудал юм.

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сангийн үндсэн зорилго нь үнэт цаасны компаниуд төлбөрийн чадваргүй болсон, харилцагчдын хөрөнгийг хууль бусаар ашигласан тохиолдолд хөрөнгө оруулагчдын хохирлыг барагдуулахад оршино. Энэхүү сан байгуулагдсанаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зөв зохистой хяналтыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхэд

хүртэл нөхөн олговор олгодог байна. Гэвч харилцагчийн өөрийн буруутай шийдвэрээс үүссэн үнэт цаасны үнийн өөрчлөлтөөс бий болсон эсхүл үйлчилгээ үзүүлэгчийн буруу зөвлөгөө авснаас шалтгаалан үүссэн хохиролд нөхөн олговор олгодоггүй байна.

Сан нь мөн хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалттай холбоотой даатгал эсхүл хадгаламжид нөхөн олговор олгодоггүй бөгөөд зөвхөн мэргэжлийн бус хөрөнгө оруулагчид буюу жижиглэнгийн

Санхүүгийн технологийн хөгжил

ФИНТЕК

Хэдхэн жилийн өмнөхтэй харьцуулахад санхүүгийн салбарын чиг хандлага асар их өөрчлөлт гарсан бөгөөд үүний нэг хэлбэр нь FINTECH буюу технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ (Finance+Technology) юм. Финтек нь

эцсийн байдлаар 307 гэрээ хэлцэл хийгдэж нийт 8.7 тэрбум долларын хөрөнгө оруулалт финтек салбарт хийгдсэн. /


5. Үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн хүртээмжийг дээшлүүлэх;

6. Ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн шийдвэр

хурдацтай явагдаж эхэлсэн нь финтекийн хөгжлийг урагш нь түлхэх томоохон хүч болсон бөгөөд финтекийн чиглэлээр гарч буй гарааны байгууллагууд олширч, хөрөнгө оруулалтыг маш ихээр татаж байна.

Ойрын 3-5 жилийн хугацаанд дэлхийн томоохон хөрөнгө оруулагч банк болон менежерүүд технологид суурилсан санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой байгаа ба хүлээгдэж буй өгөөж нь бусад салбараас илүү эрчимтэй нэмэгдэх боломжтой. Мөн 3-5 жилийн хугацаанд финтекийн чиглэлийн байгууллагууд 82%-аар өсөх хандлагатай байгаа ба дэлхийн санхүүгийн уламжлалт компаниудын дийлэнх нь буюу 88% нь финтек түншлэлтэй байгууллагад орлогоо алдах эрсдэлтэй байна.

Манай орны хувьд ухаалаг утсанд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ илүү өргөн ашиглагдаж байна. Ухаалаг утсанд суурилсан төлбөр тооцоо хийх, мөнгө шилжүүлэх, зээл авах зэрэг үйлчилгээ нь хэрэглэгчийн цагийг хэмнэх, зардлыг бууруулах, хөдөө орон нутагт үйлчилгээ авч чадахгүй байгаа хэрэглэгчдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг санхүүгийн багагүй үр өгөөжийг бий болгож байна.



Дэлхийн финтек байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалт болон гэрээ хэлэлцээрийн тоо

санхүүгийн салбарын олон асуудлыг шийдэж чадсан бөгөөд уламжлалт системийг эвдэж үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдад хүрэх үйлчилгээг сайжруулж, хэрэглэгчдэд түргэн шуурхай, хямд хүргэх бололцоог бий болгоод байна.

Бидний амьдралыг хурдацтай өөрчилж буй финтекийн талаар мэдэх шаардлагатай 6 боломж:

1. Бизнесийн өрсөлдөөнийг бодитоор нэмэгдүүлж нийгэмд үр ашиг авчрах;
2. Хэрэглэгчдэд хүрэх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг бууруулах;
3. Санхүүгийн харилцаанд гуравдагч этгээд буюу дундын зуучлагч шаардлагагүй үйлчилгээ үзүүлэх;
4. Хөрөнгө оруулалтын хэмжээг тэлж, санхүүгийн салбар дахь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх; /2017 оны жилийн

гаргалтийг хөнгөвчлөх;

Эдгээр боломжуудын нөлөөгөөр уламжлалт банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа ч улам ухаалагжиж эхэллээ. Технологийн хувьсгалд хөгжингүй орнуудын өрсөлдөөн ширүүсэж байна. Үүний давалгаанд хөгжиж буй орнууд дахь финтекийн салбар түрэгдэн урагшлах болов.

Түүхэн явцаас харахад 2000-аад оны сүүлээс дижитал ертөнцийн дэвшил маш



Нийт дижитал технологи хэрэглэгчдээс финтекийг ашиглаж байгаа хувь хэмжээ /2017 он/

РЭГТЕК

Рэгтек бол шинэлэг зүйл биш хувьсгал.

Рэгтек бол санхүүгийн салбарын зохицуулалт, нийцлийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн технологийн нэг хэлбэр. Рэгтек гэсэн үг нь "зохицуулалт" болон "технологи" гэсэн нэр томъёоны нийлэмж бөгөөд мэдээллийн технологийг тайлагнал болон дүрэм журмыг дагаж мөрдөхөд хэрхэн ашиглаж болохыг тодорхойлдог. Нөгөөтэйгүүр Рэгтек нь компаниуд өөрсдийн эрсдэлийг илүү сайн ойлгож, удирдахад нь тусалдаг.

Рэгтек бол финтекийн дэд багц:

- Финтек-санхүүгийн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээг хялбаршуулах, дижиталчилах боломжийг олгодог.

• Рэгтек-хууль, эрх зүйн салбарт хялбар, хурдан зохицож ажиллах боломжийг олгодог.

Let's Talk Payments-ийн мэдээлснээр АНУ-ын банкууд жилд 80 тэрбум долларыг хууль тогтоомжийг дагаж мөрдөх үйл ажиллагаанд болон эрсдэлийг удирдахад зарцуулдаг байна. Тэдний тооцоолсноор энэ тоо 2020 он гэхэд 119 тэрбум ам.доллар болно. Үүнээс гадна компаниуд жил бүр 160 тэрбум ам.долларыг дотоодын болон гадны шаардлагууд, хэм хэмжээ, дүрэм журмыг дагаж мөрдөөгүй байдлаас үүссэн торгуулийг барагдуулахад зарцуулдаг байна.

Рэгтекийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүд нь компаниудад дээрх зардлаа бууруулах хямд, энгийн шийдлийг санал болгодог. Одоогоор энэ зах зээлд 6000 гаруй компани оролцож байна. Орчин үеийн Рэгтек

шийдлүүд нь браузер дээр суурилсан учир зах зээлд илүү нэр хүндтэй болж, томоохон компаниудтай өрсөлдөх чадвар нь нэмэгдэн илүү хямд болж байна.

Сүүлийн 5 жилийн хугацаанд Лондонгийн Рэгтек компаниудад 39 удаагийн хөрөнгө оруулалтын хэлэлцээр хийгдсэн бөгөөд энэ чиглэлдээ тэргүүлэх хотуудын нэг болоод байна. Хийгдсэн хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн дийлэнх хувь нь мөнгө угаалтын эсрэг чиглэсэн үйл ажиллагаатай компаниудад хийгдсэн байна. Энэ чиглэлийн компаниуд нь 2014 онд 82.2 сая долларын хөрөнгө оруулалттай байсан бол 2016 оны байдлаар 334.8 сая доллар болж 4 дахин нэмэгджээ.

Эх сурвалж: FinTech Global

2018 оны хөрөнгийн зах зээлийн гол чиг хандлагууд

Хиймэл оюун ухаан нь хөрөнгийн зах зээлд өөр хэлбэрээр ашиглагдах болно. Аж ахуй нэгжүүд эрсдэлийн менежмент, арилжаа, залилан мэхлэлтийг илрүүлэх гэх мэт янз бүрийн үйл ажиллагаан дээр бүтээмжийг дээшлүүлэх үүднээс дэвшилтэд технологийг ашиглаж байна. Мөн мөнгө угаахын эсрэг (AML) болон үйлчлүүлэгчдийг танин мэдэх (KYC) шийдлүүдийг боловсруулахад ашиглаж болох бөгөөд банк болон бусад санхүүгийн байгууллагуудын мэдээллийн менежментийн чадавхыг сайжруулахад хүргэсэн гол хүчин зүйлс нь дүрэм, журам, зохицуулалтын орчин юм. *Капжэминай Консалтинг*.

Энэ салбардахь технологийн хөгжилд хиймэл оюун ухаан, автоматжуулалт, блокчейн, мэдээллийн аюулгүй байдал давамгайлсан нөлөөлөх болно. Хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшил технологитой салшгүй холбоотойг салбарт оролцогчид бүгд мэднэ. Өмчийн болон өрийн аргаар хөрөнгө босгодог компаниудад тулгамдаж буй асуудал нь үйл ажиллагаандаа шинэ технологи нэвтрүүлэх эсэхэд бус харин эдгээр технологиудад хэр хэмжээний хөрөнгө оруулалт хийх вэ гэдэгт оршино.

2018 оны Үнэт цаасны салбар ба санхүүгийн зах зээлийн холбооноос гаргасан тоймд дурдсанаар, Судалгаанд хамрагдсан дэлхийн бодлого боловсруулагчдын 27 хувь нь цахим технологийг үйлдвэрлэлийн салбарт хамгийн их дарамт учруулж, хэрэглэгчдийн зан төлөвийг 26 хувиар өөрчилж байна гэж үзжээ.

АНУ-ын Хөрөнгийн Болон Санхүүгийн Зах Зээлийн Холбоо (SIFMA)-ны тайланд дурдсанчлан хөрөнгийн зах зээлд оролцогч компаниуд хуучин системийг шинэчлэх, цахим аюулгүй байдлыг сайжруулах, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, шинэ технологийг нэвтрүүлэх зорилгоор мэдээллийн технологид хөрөнгө оруулалт хийдэг.

Технологид суурилсан зохицуулалтын шийдлүүд нь илүү үр дүнтэй, шаардлага хангасан тайлан боловсруулахад нэмэр болж чадна" гэж SIFMA тэмдэглэлээ. Мөн, блокчейн нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг автоматжуулахад тус нэмэртэй бөгөөд хиймэл оюун ухаан, Агуу мэдээлэл/ Big Data/-ийн хэрэгслүүд "харилцагчийн үйлчилгээ, үнэт цаасны портфелийн хяналтыг сайжруулахад ашиглаж болно," хэмээн SIFMA мэдээлэв.

2018 онд хиймэл оюун ухаан, автоматжуулалт, блокчейн, мэдээллийн аюулгүй байдал хөрөнгийн зах зээлийг тодорхойлох үндсэн чиг хандлага байх

болно.

Хиймэл оюун ухаан нь хөрөнгө оруулалт, шийдвэр гаргах үйл явцыг сайжруулна

Хиймэл оюун ухаан нь хөрөнгийн зах зээлд ашиг орлогыг нэмэгдүүлж байгаа учраас энэ зах зээлийн томоохон хэсгийг эзлэх нь. Голдман Саксын мэдээлснээр, дэвшилтэд технологи болон хиймэл оюун ухаан нь 2025 он гэхэд санхүүгийн салбарт жил бүр \$ 34 тэрбумаас \$ 43 тэрбум ам. доллар бүхий "зардлын хэмнэлт ба орлогын шинэ боломжууд"-ыг нээх боломжтой.

Ихэнх хөрөнгө оруулагчид хувийн



Паоло Саломео

Акссентюр Ассет Мененжмент компанийн удирдах захирал

хөрөнгө оруулалтын менежерийг үнэлэхдээ олон төрлийн хүчин зүйлсийг харгалзан үздэг. Жишээ нь, Акссентюр Ассет Мененжмент компанийн удирдах захирал Паоло Саломео менежерийн хөрөнгө оруулалтын түүх, багийн туршлага гэх мэт хүчин зүйлс нөлөөлдөг хэмээн Акссентюрын блогт бичсэн байна. Гэсэн хэдий ч тэрээр "хүчин зүйлс тус бүрт ихэвчлэн тусдаа үнэлгээ хийгддэг бөгөөд үндсэн шийдвэрийг мэргэжлийн үнэлэмж дээр үндэслэн гаргадаг" гэжээ.

Хувийн хөрөнгө оруулалтын хэд хэдэн хөрөнгө оруулагчид хиймэл оюун ухааныг аюулгүй байдал хангах үүднээс ашиглаж эхэлж байна. "Хиймэл оюун ухаан нь тоон хаалттай хувьцаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлал бага бөгөөд дэвшилтэд технологийн тусламжтайгаар шийдвэр гаргах боломж нээгдээд байна" гэж тэрээр нэмж хэлэв.

Мөн түүнчлэн хиймэл оюун ухаан нь хөрөнгийн зах зээлд өөр хэлбэрээр ашиглагдах болно. Капжэминай

Консалтинг компанийн 2018 оны хөрөнгийн зах зээлийн чиг хандлагын тайланд дурдсанаар, аж ахуй нэгжүүд эрсдэлийн менежмент, арилжаа, залилан мэхлэлтийг илрүүлэх гэх мэт янз бүрийн үйл ажиллагаан дээр бүтээмжийг дээшлүүлэх үүднээс дэвшилтэд технологийг ашиглаж байна гэжээ. Аж ахуй нэгжүүд үйлчлэгчидтэйгээ харилцах үйл явцыг шинэчлэх үүднээс унаган хэл таних технологи, чатыг ашигладаг байна.

Мөн тус технологийг мөнгө угаахын эсрэг (AML) болон үйлчлүүлэгчдийг танин мэдэх (KYC) шийдлүүдийг боловсруулахад ашиглаж болох бөгөөд банк болон бусад санхүүгийн байгууллагуудын мэдээллийн менежментийн чадавхыг сайжруулахад хүргэсэн гол хүчин зүйлс нь дүрэм, журам, зохицуулалтын орчин байсан хэмээн Капжэминай мэдээлжээ.

Хиймэл оюун ухаан нь үйл явцыг автоматжуулахад нэмэр болно

Хиймэл оюун ухаан нь хөрөнгийн зах зээл дэх компаниудын үр ашгийг нэмэгдүүлж, ялангуяа арын албаны ажлуудад туслах болно.

"Үйл явцыг автоматжуулах нь хөрөнгийн зах зээлийн компаниудын хуучин системийг солих, аудитын үл мөрийг хадгалах болон мөнгө



Гириш Патил

"Майнтри" ХХК-ийн зөвлөх

угаах, хэрэглэгчийг таних зэрэг бусад журмуудын хэрэгжилтийг хангасан системийг бий болгоход туслах болно. Мөн төрөл бүрийн тайлан, дунд болон арын албаны үйл ажиллагааг нэгтгэх" зэргийг хялбаршуулах болно гэж мэдээллийн технологийн зөвлөх




үйлчилгээ явуулдаг “Майнтри” ХХК-ийн зөвлөх Гириш Патил ярилаа. “Үйл явцыг автоматжуулах нь цаг хугацаа, мөнгийг хэмнэж, үйл явцыг хялбарчилж, бизнесийн загваруудыг дахин тодорхойлох боломжийг бий болгоно. Мөн үйл явцын автоматжуулалт нь хүмүүсийн гар оролцоотой, давтан хийгддэг байсан ажлуудыг автоматжуулна. Үйл явцыг автоматжуулах нь хөрөнгийн зах зээлийн компаниудын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд тусалж, зарим байгууллагуудын зардлыг 25-50 хувь бууруулах боломжтой гэж тооцоолж байна” хэмээн тэрээр өгүүлжээ. Зөвлөхүүдийн дүгнэлтээс үзэхэд үйл явцыг автоматжуулах нь үйлчлүүлэгчдэд нягтлан бодох бүртгэлийн үйл явц, үйл ажиллагааны болон санхүүгийн зохицуулалт, тайлан, орлогыг хүлээн зөвшөөрөх, зардлыг баталгаажуулах зэрэгт тусалж чадна.

Блокчейн хөрөнгийн зах зээлийг илүү үр ашигтай болгоно

Блокчейн нь энэ жил хөрөнгийн зах зээлийн компаниудад илүү чухал үүрэг гүйцэтгэх болно.

“Блокчейн технологи нь кодлогдсон гүйлгээ хийх идэвхжүүлсэн ухаалаг гэрээг бий болгож, хуваарилагдсан бүртгэлийг үүсгэх боломжтой. Мөн энэ нь бодит цаг хугацаанд ил тод мэдээллийг ашиглах, үр ашигтай төлбөр тооцоо, гүйлгээний боловсруулалтыг бий болгоход тусална” гэж Гириш Патил ярилаа. Блокчейн

технологи нь үнэт цаасыг гаргах, шилжүүлэхэд ашиглагдаж, төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлдэг зуучлагчдын хэрэгцээг арилгаж чадна гэж Капжэминай үзэж байна.



Брайн Коллингс

Торстон Технологи
ХХК-ийн гүйцэтгэх
захирал

Блокчейн технологи нь хөрөнгийн зах зээлийн экосистемд мэдээллийн аюулгүй, найдвартай байдлыг хангах логик, үр ашигтай хувилбар юм. Блокчейн нь “худалдааны дараах үеийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, төлбөрийн мөчлөгийн хугацааг богиносгож болзошгүй” гэж Капжэминай дурджээ.

Мэдээллийн хамгаалалт чухал ач холбогдолтой болно

Хөрөнгийн зах зээлийн олон компаниуд энэ жилийн Европын Холбооны Мэдээлэл Хамгаалах Ерөнхий Журамд онцгой анхаарал хандуулах ёстой.

Мэдээлэл Хамгаалах Ерөнхий Журамд Европын Холбооны орнуудад иргэдийн талаарх мэдээллийг цуглуулдаг аливаа компаниудад хатуу хяналтыг шинээр бий болгож байгаа бөгөөд уг

журам нь 5 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр болж хэрэгжиж эхлэх юм. Жишээлбэл, “компаниуд нь хувь хүний нэр, хаяг, нийгмийн даатгалын дугаарын мэдээллийг хамгаалдаг шиг хэрэглэгчийн IP хаягийн мэдээллийг адил түвшний хамгаалалт авах шаардлагатай болно.” Хөрөнгийн зах зээлийн компаниуд нь тус журмыг хангаж ажиллахын тулд мэдээлэл хамгаалах болон менежментийн технологигоор хөрөнгө оруулах шаардлагатай болно. Торстон Технологи ХХК-ийн гүйцэтгэх захирал Брайн Коллингс хэлэхдээ “Ингэхийн тулд

2018 онд хиймэл оюун ухаан, автоматжуулалт, блокчейн, мэдээллийн аюулгүй байдал хөрөнгийн зах зээлийг тодорхойлох үндсэн чиг хандлага байх болно.

компаниуд мэдээллийн эх сурвалжийг (мэдээллийн субъект), компанийн өөрөө эсвэл гуравдагч этгээдийг тодорхойлж, мэдээллийн шинж чанаруудын талаарх зөвшөөрлийн түвшинд зохицуулалтын хүрээнд тавигдах шаардлагыг ойлгох чадвартай гэдгийг нотлох хэрэгтэй. Мөн тэрбээр хэлэхдээ “хөрөнгийн зах зээл дэх компаниуд мэдээллийн хамгаалалтын дэд бүтцээ бэлтгэхдээ “Санхүүгийн асуудал хариуцсан удирдах байгууллага”-ын бүртгэл хөтлөх, хадгалах шаардлагуудыг нийцүүлэн хадгална” гэлээ. **ХС**

Банк бус санхүүгийн болон Даатгалын салбарын удирдах ажилтнуудын уулзалтыг зохион байгууллаа

Санхүүгийн зохицуулах хороо өнгөрөгч тавдугаар сар болон энэ зургадугаар сард банк бус санхүүгийн болон даатгалын салбаруудын удирдах ажилтны уулзалт, зөвлөлгөөнийг тус тус зохион байгууллаа.

ББСБ-уудын захирлуудтай Хороо, УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Монголбанкны удирдлагууд уулзав

V.18. “Банкнаас бусад санхүүгийн салбаруудад гарч буй өсөлт, эерэг үзүүлэлтүүдийг цаашид тогтвортой хадгалах, бататгах, мөн эрсдэлгүй найдвартай ажиллагааг хангахад төр, хувийн хэвшил нягт хамтран ажиллах нь чухал” болохыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга, доктор С.Даваасүрэн УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Монголбанкны удирдлагуудтай хамтран хийсэн Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын захирал, удирдах ажилтнуудын уулзалтыг нээх үеэрээ онцолсон юм.

төрлийн эрсдэл учрах нөхцөл хэр байгааг дүгнэн шинжлэх судалгааг засаглал, дүрэм журам, эрсдэлийн менежмент, дотоод хяналт, аудит, комплаенс, сургалт, хүний нөөц, тайлагнал гэсэн долоон бүлгийн 57 асуултаар авах юм. Мөн тэрээр Ази номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Хороо болон бусад холбогдох байгууллагаас явуулж буй ажлын талаар товч дурдсан юм. Энэ талаарх эрсдэлээс хэрхэн сэргийлэх тухай дэлгэрэнгүй зааврыг Хорооноос ББСБ-уудад гарын авлага болгон хүргүүлж буй юм.

УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны дарга Д.Дамба-Очир ч мөн дээрх асуудлаар онцлон ярьсан юм. Тэрээр, манай улс мөнгө угаах, терроризмыг

зэргийг дэлгэрэнгүй дурдав. Хууль, эрх зүйн зохицуулалтад оруулж буй өөрчлөлт, шинэчлэлтэд саналаа хэлэхийг тэрээр ББСБ-уудын захирал, удирдлагуудаас хүсээд, салбарт тулгамдаж байгаа асуудлыг



шийдвэрлэхэд Хорооны хамтаар идэвхтэй ажиллаж, дэмжин туслахаа илэрхийлэв.

Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайхан уулзалтын үеэр Хороотой санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн болон бусад хүрээнд нягт хамтран ажиллаж байгааг танилцуулан, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндэс суурь болсон санхүүгийн салбар үйл ажиллагаа, хариуцлагын хувьд эрүүл саруул байхын ач холбогдлыг онцгойлон ярилаа.

Мөн уулзалтад оролцсон Азийн хөгжлийн банкны Авилга, ёс зүйн нэгжийн захирал Хосэ Луис Секуа Монгол Улсын санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Хороо болон Монголбанкны явуулж буй идэвх чармайлтыг сайшааж, эрх зүйн орчныг шинэчлэхээс гадна батлагдсан хууль, журмыг бүрэн хэрэгжүүлэх асуудал нэн чухал болохыг онцолсон юм.

Уулзалтын дараа ББСБ-ын удирдах ажилтнуудад зориулсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд ББСБ-ын оролцоо” сэдэвт сургалт боллоо. Сургалтаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоо болон ББСБ-ын энэ асуудлыг хариуцсан ажилтан, түүний чиг үүргийн талаар Хорооны Захиргаа удирдлагын газрын



Тэрээр хэлсэн үгэндээ, банк бус санхүүгийн салбарт Хорооноос явуулж байгаа чадавхжуулах бодлого, түүний үр дүнгийн талаар товч дурдан, ойрын үед ББСБ-уудаас авахаар төлөвлөж буй эрсдэлийн судалгааны талаар танилцуулсан юм. ББСБ-уудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чадавх, нөөц ямар байгаа, энэ

санхүүжүүлэх тогтолцоо гүйцэт бүрдээгүй улс орнуудын саарал жагсаалтад орохгүй байхад санхүүгийн бүх салбар, нэгжүүд дор бүрнээ анхаарч ажиллах шаардлагатайг тэмдэглэж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хийгдэж байгаа ажлууд, мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн найруулахаар ажиллаж байгаа

дарга, доктор Б.Батзориг, ББСБ-ын газрын мэргэжилтэн У.Ганчимэг нар дэлгэрэнгүй танилцууллаа. Хуулийн тодорхойлолтууд, тэдгээрийг хэрхэн ойлгох, дагаж мөрдөх, мөн санхүүгийн байгууллагад тухайн асуудлыг эрхлэн хариуцсан ажилтан буюу комплаенсын ажилтан ямар эрх хэмжээ, чиг үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлдэг талаар тус сургалтаар ББСБ-ын удирдлагуудад тодорхой, дэлгэрэнгүй ойлголтыг өглөө.

Мөнгө угаах гэмт хэрэг гэдэгт хууль бус орлого, мөнгийг мэдсээр байж авч, хувиргасан буюу хууль ёсны болгоход нь тусалсан бүхий л үйлдлийг хамруулдаг. Олон улсын болон бүс нутгийн санхүүгийн харилцаа ихээхэн интеграцчлагдсан өнөө үед бохир мөнгийг цэвэршүүлэх үйл ажиллагааны цар хүрээ ихээхэн тэлж буйг мэргэжилтнүүд анхааруулж байгаа юм. Ялангуяа хөгжиж буй болон буурай хөгжилтэй улс орнуудын зах хязгаарын, мөн хүн ам сийрэг болон төрийн зохицуулалт сул бүс нутгуудад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх магадлал өндөр байдаг байна.

Сургалтаар ББСБ-ууд уг гэмт хэрэг, үйлдлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, сэрэмжлэн хамгаалах учиртайг болон Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан, санхүүгийн гэмт хэргээс хамгаалах тогтолцоо ямар хэмжээнд бүрдсэн зэрэг өргөн хүрээний сэдвийг хөндсөн юм. Мөн ББСБ-уудад комплаенсын ажилтан байснаар бизнесийн нэр хүнд унах, мөнгө угаахтай холбоотой эрсдэл өртөхгүй байж болохыг онцлон ярилцав.

Уулзалт, сургалтад нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 132 ББСБ-ын удирдах албан тушаалтнууд оролцлоо. ББСБ-ын удирдах ажилтнууд санхүүгийн зохицуулагч байгууллагын удирдлага, Монголбанк, УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны удирдлагуудтай хийсэн тус уулзалтын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байв.

Даатгалын салбарын удирдах ажилтны уулзалтыг “Асуудал ба шийдэл” сэдвээр явууллаа

VI.13. Санхүүгийн зохицуулах хороо Даатгалын салбарын удирдах ажилтны хэлэлцүүлгийг “Даатгалын салбарын асуудал ба шийдэл” сэдвийн хүрээнд өрнүүлээ.

Хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ Хорооны дарга, доктор С.Даваасүрэн, “Даатгалын зах зээлд гарч байгаа өсөлтийг цаашид хэрхэн тогтвортой үргэлжлүүлэх вэ? Салбарын хөгжлийг хэрхэн хангаж, хууль эрх зүйн орчныг ямар концепцоор боловсронгуй болгох учиртай вэ? Бид хэрхэн чадавхиж, санхүүгийн бусад салбар, зах зээлүүдтэйгээ хэрхэн уялдаж хөгжих ёстой вэ?” гэсэн асуултуудыг тус



салбарын удирдлага, мэргэжилтнүүдийн дунд нээлттэй тавилаа. Мөн тэрээр, хэдийгээр төр, засгийн бодлого, зорилтууд зохих хэмжээнд тодорхойлогдсон байгаа ч улам өндөр үр дүнг эрмэлзэж ажиллах үүднээс бид нэн түрүүнд тулгамдсан асуудлуудаа ярьж, гарц, шийдлээ хэлэлцэн, харилцан ойлголцол, нягтрал, хамтын ажиллагаагаа сайжруулах нь юу юунаас чухал байна гэсэн юм.

Хорооны Даатгалын газрын дарга М.Өлзийбат Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт даатгалын зах зээлийн чиглэлээр туссан зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцууллаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хороо даатгалын салбарын хууль эрх зүй, зохицуулалтын орчныг үе шаттайгаар шинэчлэх, мөн олон улсын даатгалын тулгуур зарчим, стандартуудыг судалж, нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих бодлого баримтлан ажиллаж байна. Мөн иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлага, зохицуулалтын тогтолцоог сайжруулах зэрэг олон ажлыг эхлүүлээд

байгаа юм байна.

Хөтөлбөрт туссан зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар хэлэлцүүлэгт оролцогчид санал, бодлоо хэлж, зах зээлд тулгамдаж байгаа асуудлууд, тэр дундаа даатгалын цахим бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, хураамжийн зохицуулалт болон татварын орчныг бодлогоор дэмжих зэрэг өргөн хүрээний асуудлыг хөндөж, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой санал дэвшүүлж ярилцав.


Түүнчлэн хэлэлцүүлгээр, Монголын даатгалын холбооны удирдах зөвлөлийн дарга П.Эрдэнэбаатар, Албан журмын даатгалын холбооны гүйцэтгэх захирал Д.Цэвээнжав нар салбарын хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилт болон даатгалын салбарын хөгжлийн хандлагын талаар илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм.

Удирдах ажилтны хэлэлцүүлэгт тус зах зээлийн оролцогч байгууллагуудаас гадна Сангийн яам, Монголбанк болон арилжааны банкуудын удирдах албан тушаалтнууд оролцож, зах зээлийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд болоод тэдгээрийг шийдвэрлэх арга замын талаар тус тусын байр суурийг илэрхийлэв.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн бүтэц

Монгол Улсын хөрөнгийн зах зээл нь дотроо хувьцааны, бонд (өрийн бичиг)-ын гэж хоёр хуваагддаг. Түүнчлэн арилжаалагдаж буй бүтээгдэхүүний шинэ хуучин эсэхээс хамаарч хөрөнгийн зах зээл нь анхдагч болон хоёрдогч гэж ангилагддаг. Анхдагч хөрөнгийн зах зээлд

Засгийн газар эсвэл компанийн бонд болон хувьцаагаа анх удаа шинээр санал болгож, улмаар “босгосон” мөнгөөрөө үнэт цаас гаргасан төслөө санхүүжүүлдэг. Харин хоёрдогч зах зээлд хөрөнгө оруулагчид өмнө нь худалдан авсан үнэт цаасаа хоорондоо арилждаг.



А.Авир: Омбудсмений тогтолцооны эрх зүйн орчныг бий болгоно

Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хуулийн төслийг ирэх сард боловсруулна

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын ахлах хянан шалгагч А.Авиртай ярилцлаа.

А.Авир



"...Санхүүгийн зах зээлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах шүүхийн өмнөх шатны эрх зүйн тогтолцоо бүрдээгүй байна..."

-Хөрөнгийн зах зээлд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр Хорооноос ямар ажлууд хийж байгаа талаар яриагаа эхлүүлье.

-Төрөөс хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалж буй үйл ажиллагааг шууд утгаар нь нэг талыг барьж хамгаална гэж ойлгохоос илүүтэйгээр тэдгээрийн хөрөнгө оруулах шийдвэр гаргахад нөлөөлөх санхүүгийн болоод санхүүгийн бус тайлан, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хэн нэгэнд давуу байдал олгохгүй, мэдээллийн гажуудлыг үүсгэхгүй, зах зээлд дээр шударга байдал бий болгоход хяналт тавих, иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх гэж ойлгож болно. Санхүүгийн зохицуулах хорооны тухайд эрх зүйн байдлын тухай хуулиар санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг олгосон байдаг. Энэ хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчид, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Хороо Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны хамтран баталсан "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021"-ийг хэрэгжүүлж байна. Энэхүү үндэсний хөтөлбөрийн дагуу дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага, өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн мэдлэгийн түвшинг харгалзан залуу үе, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох чиглэлээр ажиллаж байгаа. Мөн санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хангах, хамгаалах талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаа, тэдгээрийн үр

дүнг дээшлүүлэх, уялдуулах зорилгоор Монголбанк, Сангийн яам, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Монголын Ипотекийн Корпораци, Хадгаламжийн даатгалын корпораци, Бичил санхүүгийн хөгжлийн сан, Монголын банкны холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах аян"-ыг зохион байгуулж байна. Өнгөрсөн гуравдугаар сарын 15-нд "Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр" Хороо үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, банкны салбарын 150 гаруй төлөөлөгч, санхүүгийн зохицуулагч байгууллагуудын төлөөлөл оролцсон "Санхүүгийн хэрэглэгчийн хамгааллын өнөөгийн нөхцөл байдал" сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан байгаа.

-Хэлэлцүүлгээр ямар асуудлууд хөндөгдсөн бэ?

-Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, хангах тогтолцоо зэрэг өргөн хүрээний асуудлаар санал солилцсон. Тэр дундаа иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлж, зохицуулалтын бодлого, хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах, гэрээний харилцаа болон зохицуулалтын технологийг хөгжүүлэх шаардлагатай талаар хэлэлцүүлэгт ирсэн оролцогчид санал нэгдэж, зохих түвшинд хамтран ажиллахаар тогтсон.

-Хувьцаа эзэмшигч хохирсон тохиолдолд хуулиараа ямар арга хэмжээ авдаг вэ?

-Иргэн хуулийн этгээд нэгэнт хөрөнгө оруулснаар аль нэгэн нээлттэй компанийн хувьцаа эзэмшигч болсон тохиолдолд тухайн компанийн үйл хэрэгт оролцох эрхийг нь эдлүүлэх, эцэст нь хэрэв мэргэжлийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас эрх нь хөндөгдсөн тохиолдолд шүүхийн өмнөх шатанд урьдчилан шийдвэр гаргах, гэмт хэргийн шинжтэй үйлдлээс болж хувьцаа эзэмшигч хохирсон бол хохирлыг дундын сангаас нөхөн олгодог.

Манай улсад хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгааллын өнөөгийн байдал ямар байна вэ?

-Манай орны хувьд санхүүгийн зах зээлд дээр хувьцаа эзэмшигчийн эрхийн хамгаалал боломжийн түвшинд

хөгжсөн гэж үзэхээр байна. Давуу талаас нь дурдвал, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуулиар хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг олгосон байгаа нь G20-ийн зарчимд нийцсэн бол зарим орнуудын тухайд шинээр хуульчлах шаардлага үүсээд байна. 2015 онд санхүүгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор хяналт шалгалт, зохицуулалтын газрыг Хорооны бүтцэд шинээр бий болгож, тус газарт санхүүгийн хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хуулиар олгогдсон чиг үүрэг бүхий чиглэлийн нэгжийг байгуулаад ажиллаж байна.

Мөн Хороо нь Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 2016-2021"-ийг батлан хэрэгжүүлээд явж байна.

Түүнчлэн эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах үүднээс "Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг Сангийн яам, Монголбанк, Хороо хамтран боловсруулж, Засгийн газрын 2017 оны 299 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналт, зохицуулалтын орчны үнэлгээг хийх, зохистой хяналт шалгалтыг зааглах, хамгааллын эрх зүйн тогтолцоо, мэдээллийн ил тод байдлыг хангах, олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн хүртээмжийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх зорилгыг тусгасан зэрэг нь суурь нөхцлийг бүрдүүлээд байна.

-Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн хамгааллын өнөөгийн нөхцөл байдлаас харахад хүндрэлтэй зүйл юу байдаг вэ?

-Давуу талууд байхын зэрэгцээгээр бэрхшээл, хүндрэлүүд цөөнгүй байна. Тухайлбал, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах сангийн тогтолцоо бүрдээгүй, олон нийтийн санхүүгийн мэдлэг дутмагаас өөрсдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах тухай ойлголт иргэдийн дунд хангалтгүй байгаа нь бэрхшээлийг үүсгэж байна. Хорооны санхүү, төсвийн хязгаарлагдмал байдалтай холбоотойгоор орон нутагт үйл ажиллагаа явуулж буй тусгай

зөвшөөрөл эзэмшигчид, мэргэжлийн оролцогчид болон иргэдэд чиглэсэн сургалт, мэдээллийн хүртээмж хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байна. Одоогийн байдлаар санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиг үүрэг нь хяналт шалгалт, зохицуулалтын газрын бусад чиглэлүүдийн зохистой /prudential/ хяналт шалгалтын чиг үүрэгтэй давхацсан, хэрэглэгчийн эрхийг хамгаалах голлох үйл ажилбар өргөдөл, гомдол шийдвэрлэхэд хамаарч байгаа нь зохицуулалтыг шинэчлэн сайжруулах, зах зээлийн мэдээлэлд суурилсан судалгаа, шинжилгээ хийх болон мэдээллийн ил тод байдал, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, өргөдлийг хүлээн авах, барагдуулах зэргийг цахимжуулах гэх мэт асуудлуудыг шийдвэрлэхэд нөөц хангалтгүй байгаа. Эцэст нь хэлэхэд санхүүгийн зах зээл дахь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах шүүхийн өмнөх шатанд маань санхүүгийн зах зээлийн маргаан шийдвэрлэх механизм болон хөрөнгө оруулагч, даатгуулагчийг хамгаалах сангийн эрх зүйн тогтолцоо бүрдээгүй байна.

Цаашид санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тал дээр ямар чиглэлийг баримтлан ажиллах вэ?

- Их 20, OECD, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын зарчим, судалгаа, зөвлөмжид тулгуурлавал, өнөөгийн санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагаа нь зохицуулалттай байгууллагын зохистой хяналт шалгалттай сонирхлын зөрчил үүсдэг, ажлын хийдэл, давхардал үүсгэдэг, нөөцийн үр ашгийг бууруулдаг тул "Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналт"-ын нэгжийг тусад нь бий болгох шаардлагатай. Хяналтын нэгжийн эрх хэмжээ, чиг үүрэг нь зохицуулалт, бодлого боловсруулах, зайны болон газар дээрх хяналтыг хэрэгжүүлэх, судалгаа, дүн шинжилгээ хийх, мэдээллийн нээлттэй байдлыг хангах зэрэг юм. Өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хяналтын үйл ажиллагааг зохицуулалттай байгууллагын зохистой хяналт шалгалтаас маш тодорхой журамлан зааглаж, бие даасан хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ гэсэн үг. Хорооноос хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй ашиглах үүднээс хяналтын нэгж нь үйл ажиллагааны хамгийн үр нөлөө бүхий тэргүүлэх чиглэлийг сонгох нь чухал, иймээс санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх бус санхүүгийн зах зээлийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал /transparency/-д нэгжийн үйл ажиллагааг төвлөрүүлж, энэ тал дээр нэгжийн ажилтнуудыг чадавхжуулж, мэргэшүүлэхээр ажиллаж байна. Учир нь мэдлэг, мэдээлэлтэй хэрэглэгчийн эрх ашиг хөндөгдөх магадлал бага юм.

Түүнчлэн Монголбанк, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Хорооны төлөөлөл Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт орж, гадаад орнуудын дэвшилтэт туршлага, тухайн орнуудын ижил хуулиудыг судалж, энэ оны 6 дугаар сарын нэгний дотор хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. Учир нь Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гарсан маргааныг хуулийн дагуу шүүхийн өмнөх шатанд урьдчилан шийдвэрлэдэг бөгөөд энэхүү хуулийн төсөлд шүүхийн өмнөх шатанд санхүүгийн маргаан шийдвэрлэх бие даасан хараат бус механизм буюу омбудсмений тогтолцооны эрх зүйн орчинг бий болгохоор төлөвлөж байна.

-Санхүүгийн зохицуулах хорооноос санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах стратеги төлөвлөгөөг боловсруулсан гэж байсан. Энэ тухайд?

Хорооноос санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэглэгчийг хамгаалах хяналт, зохицуулалтын эрх зүйн орчин боловсронгуй болгох, санхүүгийн байгууллагын бизнесийн үйл ажиллагааны

Хэрэв мэргэжлийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас эрх нь хөндөгдсөн тохиолдолд шүүхийн өмнөх шатанд урьдчилан шийдвэр гаргах, гэмт хэргийн шинжтэй үйлдлээ болж хувьцаа эзэмшигч хохирсон бол хохирлыг дундын сангаас нөхөн олгодог.

хариуцлагыг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нэгжийн үйл ажиллагааг чадавхжуулах зэрэг үндсэн гурван зорилтын хүрээнд хэрэгжүүлэх юм. Энэ гурван зорилтын хүрээнд хяналт, зохицуулалтын эрх зүйн орчны үнэлгээг IOSCO, IAIS, OECD, AFI зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт тогтоогч байгууллагын зарчмын дагуу гүйцэтгэж, дунд хугацааны төлөвлөгөө болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналтын бие даасан журмыг хэрэгжүүлэх, санхүүгийн байгууллагуудад өргөдөл, гомдлын мэдээллийн нэгдсэн санг бий болгож, санал, хүсэлт өргөдөл, гомдлыг хүлээн авах, барагдуулах, шаардлагатай мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг цахимжуулах, олон нийтэд хүргэж буй тайлан, мэдээллийг шинэчилсэн стандартад

оруулах, компанийн засаглалыг сайжруулж, хараат бус, хүчтэй дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэглэгчийн мэдээллийн хамгаалалт, нууцлалыг сайжруулах зэрэг бэлтгэл ажлууд хийгдэж эхлээд байна.

-Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны хамрах хүрээ өргөн. Тэгэхээр хяналтын шатны мэргэжилтнүүдийн шалгуур, ур чадвар тэр хэрээр өндөр байдаг уу?

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны хамрах хүрээ өргөн байдгаас Хорооны болон санхүүгийн байгууллага дахь санал, хүсэлт өргөдөл, гомдлыг хүлээн авах, барагдуулах ажилтнууд мэргэжлийн ур чадвар, тухайн салбарт ажилласан ажлын туршлагатай байх ёстой, цаашид ч үргэлжлүүлэн мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулах шаардлагатай байдаг. Учир нь төрийн ч бай, бизнесийн ч байгууллагын үйл ажиллагааг дүгнэх үйл явцад хэрэглэгч буюу иргэд, олон нийтээс өгсөн үнэлгээ чухал байр суурь эзэлж, чухал голлох үзүүлэлт болдог. Иймд санхүүгийн зах зээлд оролцогчид үүнд онцгой анхаарч, дээрх ажилтнуудын томилгоонд ач холбогдол өгөх шаардлагатай ба хэрэв үүнийг эс тооцвол, дээр дурдсан зорилгоос эсрэг нөлөө, үр дүн гарах эрсдэлтэй.

Энэ оны эхний байдлаар Хороонд ирүүлж буй өргөдөл гомдол хэр зэрэг байна?

2018 оны 1 дүгээр улирлын байдлаар Хороонд санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн асуудлаар нийт 98 өргөдөл, гомдлыг ирүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөн байна. Харьцуулалтаар, тайлант улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон үзүүлэлтүүд банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт 58.6, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 17.8 хувиар өссөн бол даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол 2.4 хувиар тус тус буурчээ. Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчдээс 26 өргөдөл ирүүлснээс нийт өргөдлийн 43 хувийг өмчлөгчийн зөвшөөрөлгүй хувьцаа арилжаалсан гомдлууд эзэлсэн байна. Эдгээр гомдлуудад дурдсан өмчлөгчийн зөвшөөрөлгүй хувьцааг арилжаалсан үйлдлүүд нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 17 брокер, дилерийн компаниар дамжуулан 2000 оноос өмнө үйлдэгдсэн байдаг. Эдгээр тохиолдлууд нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах учир Хорооны хянан шалгагчид зөрчлийн хэрэг нээн прокурорын байгууллагын хяналтан дор хянан шийдвэрлэж байна. **ХС**

Иргэдийн өргөдлийг хэрхэн шийдвэрлэдэг вэ?

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар Хорооны үндсэн чиг үүргийг тодорхойлсны нэг нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах юм. Хороо энэ чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс Хяналт шалгалт, зохицуулалтын газрынхаа бүтцэд Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах нэгж ажиллуулж байна. Тус газар, нэгж нь иргэдэд санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх явцад гарсан аливаа асуудал, зөрчил маргааныг өргөдөл, гомдлыг үндэслэн хуулийн дагуу хянан, шийдвэрлэх ажлыг шуурхай гүйцэтгэдэг. “Хүртээмжтэй санхүү” дугаар бүрээрээ Хэрэглэгч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах нэгжид ирж, шийдвэрлэгдсэн бодит өргөдөл, гомдлын жишээнд тулгуурлан уншигчдад сургамжтай, өгөөжтэй баримтуудыг цувралаар хүргэж байх болно.

Гарын үсэг

Тус Хороонд иргэн “Б”-ээс түүний өмчлөлийн “В” ХК-ийн 24 ширхэг хувьцааг зөвшөөрөлгүй арилжаалсан тухай өргөдлийг 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр гаргасан байна.

Уг өргөдөл нь Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах магадлалтай тул Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын хянан шалгагч, улсын байцаагч “А” нь Баянхонгор аймаг, ... тоот хаягт оршин суух тоот регистрийн дугаартай иргэн “Б”-ийн эзэмшлийн “В” ХК-ийн 24 ширхэг хувьцааг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжаалсан гэх зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хянасан байна.

Өргөдлийг хянах явцад, дээр дурдсан хувьцааг 1999 оны 3 дугаар сарын 22-ны өдөр тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн “Г” ХХК-аар дамжуулан арилжаалагдсан нь харилцагчийн үнэт цаасны дансны дэлгэрэнгүй хуулгаар нотлогджээ.

Иргэн “Б”-ийн гомдолтой танилцахад, Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.10 дугаар зүйлийн 2.20 дахь хэсгийг зөрчсөн үйлдэлд хамаарах боловч тус үйлдэл нь 1999 онд үйлдэгдсэн, “ҮЦТХТ” ХХК-иас гаргуулсан архивын анхан шатны баримтаар уг хувьцааг арилжаалахаар 1999 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 155 тоот захиалгын гэрээг үйлдэж, холбогдох гарын үсэг зурагдсан, “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас анхан шатны баримтын архивын лавлагааг гаргуулан авахад, дээр дурдсан хувьцаа зарсны мөнгийг 1999 оны 3 дугаар сарын 26-ны өдөр иргэн “Б”-ийн 00-0000 тоот хадгаламжийн данснаас өөр данс руу мөнгөн хөрөнгө шилжүүлэх өргөдөл үйлдэгдэж, уг өргөдөлд холбогдох гарын үсэг зурагдсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь аливаа иргэний гарын үсгийн үнэн зөвийг тогтоох эрх бүхий байгууллага биш бөгөөд

анхан шатны баримтад үндэслэвэл хувьцааг зөвшөөрөлгүй зарсан гэж үзэх үндэслэлгүй тул уг гомдол нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжгүй нөхцөл байдал тогтоогдсон болно.

Иймд иргэн “Б”-д өргөдлийг хянасан талаар болон Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д “Хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэнэ” гэж заасны дагуу үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх



тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон “Г” ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэх боломжгүй, мөн хувьцааг зарах болон мөнгөн хөрөнгө шилжүүлэх анхан шатны баримтад холбогдох гарын үсэг зурагдсан байх ба тус Хороо нь уг гарын үсгийн үнэн зөвийг тогтоох эрх бүхий байгууллага биш болохыг албан бичгээр мэдэгдсэн байна.

Түүнчлэн уг албан бичигт хэрэв иргэн “Б” нь дээрх анхан шатны баримтад зурагдсан гарын үсэг хууль бус, хуурамч гэж үзвэл иргэний журмаар шүүхэд хандан асуудлаа шийдвэрлүүлэх боломжтойг дурдаад “Г” ХХК-ийн тухайн үед ажиллаж байсан эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, хувьцаа зарах захиалгын

гэрээ болон төвлөрсөн хадгаламжинд данстай харилцагчдын хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэх өргөдлийн хуулбарыг хавсарган хүргүүлсэн байна.

1072-ыг өвлөх үү?

“А ҮЦК” ХХК-иас үнэт цаасны дансаа нээлгэж амжаагүй нас барсан иргэний нэр дээр бүртгэлтэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг гэр бүлийн бусад гишүүнд нь өвлүүлэх боломжтой эсэх талаар тодруулга хүссэн албан бичгийг тус Хороонд 2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн байна.

Албан хүсэлтийг хянах явцад “ҮЦТХТ” ХХК-д хандан албан ёсны тайлбарыг гаргуулан, түүн дээр үндэслэн дараах тодруулгыг “А ҮЦК” ХХК-д албан бичгээр хүргүүлсэн байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 3-т “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны хоёрдахь зах зээлийн арилжаа эхлэх хүртэл хугацаанд энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хувьцааг саналын эрхгүй, Засгийн газарт нэрлэсэн үнээр нь худалдахаас бусад тохиолдолд аливаа хэлбэрээр захиран зарцуулахгүй байх нөхцөлтэйгээр иргэдэд эзэмшүүлнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК нь хувьцаагаа олон нийтэд санал болгохгүй, зөвхөн биржээр нээлттэй арилжаалагдсан үед хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцаагаа бусдад шилжүүлэх, тухайлбал, барьцаалах, бэлэглэх, өвлүүлэх болон худалдах зэргээр эдийн засгийн эргэлтэд оруулна.

Иймд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалах тухай Засгийн газрын тогтоол гарсны дараа тухайн нас барсан иргэний гэр бүлийн гишүүн нь хуулийн дагуу баримтаа бүрдүүлэн “ҮЦТХТ” ХХК-д хандан өвлөх эрхийн асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой гэдгийг албан ёсоор мэдэгдэж хувийг “ҮЦТХТ” ХХК-д илгээсэн байна. **ХС**

Зах зээлийн мэдээ

Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 81.3 хувиар өслөө

Энэ оны эхний улирлын байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2.6 их наяд төгрөгт хүрч, 2017 оны нэгдүгээр улирлынхаас 1,2 их наяд төгрөгөөр буюу 81.3 хувиар өслөө. Энэ нь улирлын ДНБ-ий 39.1 хувьтай тэнцсэн бөгөөд нийт зах зээлийн үнэлгээний 78.3 хувийг 10 компани бүрдүүлжээ.


Улирлын дүнгээр зах зээлд нийт 17.7 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж, дээрх зах зээлийн үнэлгээнд харьцуулсан хувьцааны хөрвөх чадвар 0.7 хувь болов.



Давхар даатгалын хураамжийн зардал буурч байна

Даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2018 оны нэгдүгээр улиралд ноднингийн мөн үеийнхээс 14.9 хувиар өсөж, 258.3 тэрбум төгрөгт хүрээд байна. Үүний 79.8 хувийг ердийн даатгалын, 17.1 хувийг давхар даатгалын, 3.0 хувийг урт хугацааны даатгалын компаниудын хөрөнгө тус тус бүрдүүлэв.

Хураамжийн орлого 2017 оны нэгдүгээр улиралд 37.8 хувийн өсөлттэй байсан бол энэ оны эхний улиралд улиралд 5.8 хувиар бууран 35.3 тэрбум төгрөг боллоо. Орлогын 19.0 хувийг даатгалын зуучлагчид, 21 хувийг даатгалын



төлөөлөгчид бүрдүүлсэн байна. Харин нийт нөхөн төлбөрийн зардал тус улиралд 11.5 тэрбум төгрөгт хүрч, хураамжийн орлогын 32.7 хувийг эзлэв. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 31.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

Манай дийлэнх даатгалын компаниуд гадаадын давхар даатгалын компанид эрсдэлээ даатгадаг. Энэ оны эхний улирлын байдлаар нийт 12.6 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг шилжүүлсэн нь 2017 оныхоос 37.3 хувиар буурчээ.

ХЗХ-д сүүлийн зургаан жилд анх удаа 30 хувийг давсан өсөлттэй ажиллав

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-ны салбарын нийт актив энэ оны нэгдүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.0 тэрбум төгрөгөөр буюу 32.1 хувиар өсч, 160.8 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь сүүлийн зургаан жилд анх удаа 30-аас дээш хувиар өссөн үзүүлэлт юм.

ХЗХ-дын нийт зээлийн багц 117.9 тэрбум төгрөг байгаа нь активын 73.3 хувь болж байгаа бол татан төвлөрүүлсэн



ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө, хадгаламж /тэрбум төгрөг/


хадгаламжийн үлдэгдэл 108.0 тэрбум төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 67.2 хувийг бүрдүүлж байна. Өнгөрсөн онуудтай харьцуулахад хадгаламжийн хэмжээ хамгийн өндөр буюу 44.7 хувийн өсөлттэй байгаа бөгөөд 96.8 хувь нь хугацаатай, 3.2 хувь хугацаагүй хадгаламж байна. Харин хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум төгрөгөөр буюу 9.9 хувиар өсч, гишүүдийн тоо 9,741-ээр нэмэгдэн 57,659 боллоо.

Хоршоодын нийт орлого энэ улиралд 40.8 хувиар, нийт зардал 44.2 хувиар тус тус өссөнөөс шалтгаалан цэвэр орлого 0.5

тэрбум төгрөг болж 2017 оны нэгдүгээр улирлынхаас 4.4 хувиар буурчээ.

Банк бус санхүүгийн салбарт явуулж буй чадавхжуулах бодлогын хэрэгжилт сайн байна

Өнөөдрийн байдлаар банк бус санхүүгийн зах зээлд нийт 537 ББСБ ажиллаж байгаагийн 90.5 хувь нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Салбарын нийт хөрөнгийн хэмжээ энэ оны эхний улиралд 1.05 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 31.1 хувиар өслөө. Үүний 82.3 хувийг зээлийн өсөлт бүрдүүлсэн байна.



ББСБ-уудын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү

ББСБ-уудын өөрийн хөрөнгийн хэмжээ 811.3 тэрбум төгрөгт хүрч, 2017 оны эхний улирлынхаас 27.7 хувиар өссөн бөгөөд энэ өсөлтийн 77.2 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт эзэлж байна. Хороо 2016 оны 10 дугаар сараас ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттайгаар нэмэгдүүлж, чадавхжуулах бодлого хэрэгжүүлж байгаа бөгөөд уг бодлогын хэрэгжилт сайн байна. Үр дүнд нь ББСБ-ын зээлийн нийлүүлэлт сайжран, нэгдүгээр улирлын байдлаар зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 3.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр буурлаа.

Санхүүгийн зах зээлд итгэх иргэдийн итгэлийн индексийг танилцууллаа

Санхүүгийн зохицуулах хороо хөндлөнгийн мэргэжлийн судалгааны байгууллагатай хамтран ажиллаж, зах зээлийн төлөв байдал, иргэд, хөрөнгө оруулагчид болон зах зээлийн тоглогчдын хүлээлт ямар байгаа зэргийг тандан судалж байна. Бодлого, төлөвлөлтийг судалгаанд суурилан хийж, бодитойгоор, бүрэн гүйцэт хэрэгжүүлдэг байх нөхцөл, шаардлага



бий болсон өнөө цагт өндөр мэргэжлийн судалгааны байгууллага, институттэй нягт хамтран ажиллах нь ихээхэн чухал юм.

Хороотой хамтран ажилладаг “NRCC” судалгааны байгууллага 2016 оны гуравдугаар улирлаас эхлэн улирал тутам иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийн судалгааг тогтмол хийж байна. Санхүүгийн салбарт хэрэгжүүлэх төрийн зохицуулалтыг төлөвлөхөд шаардлагатай бодит мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх, бодлогын хэрэгжилтийн хугацаанд иргэдийн итгэл, зах зээлийн талаарх мэдлэг, зах зээлийн оролцоонд гарч буй өөрчлөлтийг тандах зорилгоор явуулж буй уг судалгааг санамсаргүй түүврийн аргаар улсын хэмжээнд 1000 орчим иргэдийг хамруулж, 2016 оны гурав, 2017 оны нэг, хоёр, 2018 оны нэгдүгээр улирлуудад буюу нийт дөрвөн улиралд тандан судалсны дүнг энэ сарын эхэнд Хорооны Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн дарга Н.Хүдэрчулуун, “NRCC” судалгааны байгууллагын судлаач Б.Алтанцэцэг, Б.Соёлмаа нар танилцууллаа.

Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл 2017 оны мөн үетэй харьцуулахад харьцангуй тогтвортой байна. Харин Хороо, банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон даатгалын салбарт зарим өөрчлөлтүүд ажиглагдсан байна. Өөрөөр хэлбэл Хороонд итгэх итгэл өмнөх оны мөн үеэс 40 хувиар өсч, мэдэхгүй гэсэн хариулт 10 хувиар буурсан бол ББСБ-д итгэх итгэл 20 хувиар өсч, мэдэхгүй гэсэн хариулт 40 хувиар буурчээ. Дөрвөн удаагийн судалгаагаар санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл нас, боловсрол, орлого, байршил болон сууцны нөхцлөөс хамааран ялгаатай байдаг нь ажиглагдаж байна. Ерөнхий дүр зургийн хувьд боловсрол

өндөр, насаар залуу, орон сууцанд амьдардаг, орлого сайтай иргэдийн хувьд санхүүгийн байгууллагуудад итгэх итгэл сайн байна.

Харин эрэгтэйчүүдийн хөрөнгийн биржид итгэх итгэл эмэгтэйчүүдийнхээс илүү байгаа бөгөөд 35 ба түүнээс доош настай хүмүүсийн хөрөнгийн биржид итгэх итгэл 35-аас дээш настай иргэдтэй харьцуулахад 60 хувь илүү, хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-нд итгэх итгэл 75 хувиар илүү байна. Сайн дурын даатгалд хамрагдалт болон даатгалын талаарх мэдлэгийг бүлгээр харахад нас, орлого болон сууцны нөхцлөөс хамааран өөр байна. 35-аас дээш настай, орлого өндөртэй, орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд даатгалд хамрагдалт өндөр, мэдлэг сайтай байна.

ББСБ-д итгэх итгэл орон сууцанд амьдардаг иргэдийн хувьд гэр хороололд амьдардаг иргэдтэй харьцуулахад 25 хувиар сайн байна. Эрүүл мэндийн даатгалыг иргэдийн 46.5 хувь нь хамгийн хэрэгцээтэй гэж үзэж байна. Үүний дараа гэнэтийн осол, эмчилгээний даатгал (20 хувь)-ыг нэрлэжээ. Иргэдийн 6.3 хувь нь энэ асуултанд сайн мэдэхгүй гэж хариулсан. Иргэдийн орлого, байршил хоёроос хамааран даатгалын хэрэгцээ шаардлага өөр өөр байна. Хөрөнгийн даатгалыг хэрэгтэй гэж орлого өндөртэй иргэдийн 8.9 хувь нь хариулсан байгаа нь орлого багатай иргэдтэй харьцуулахад бараг хоёр дахин их байна.

Жилийн өмнө судалгаанд оролцсон иргэдийн 33.2 хувь нь зээлийн үйлчилгээ авч байсан бол 2018 оны нэгдүгээр улирлын байдлаар, иргэдийн 44.0 хувь

буюу бараг тал нь зээлийн үйлчилгээ авчээ. Үүнд нийт иргэдийн 30.2 хувь нь арилжааны банкнаас, 10.5 хувь нь ломбарднаас, 9.4 хувь нь ББСБ-аас, 9.4 хувь нь хувь хүнээс авчээ. Иргэдийн авсан нийт зээлийн тоонд арилжааны банк 50 хувь, ББСБ 16 хувь, ломбард 17 хувь, хувь хүн 15 хувийг эзэлж байна. Жилийн өмнө буюу 2017 оны нэгдүгээр улирлын судалгаагаар иргэдийн авсан зээлд арилжааны банк 58 хувь, ломбард 13 хувь, ББСБ 5 хувь эзэлж байжээ. Зээл авсан иргэдэд ББСБ-ын эзлэх хувь 11 пунктээр өссөн бол арилжааны банкны эзлэх хувь 8.0 пунктээр буурсан байна. Арилжааны банкнаас хөдөө амьдардаг, эмэгтэй болон 35-аас дээш насны хүмүүс илүү их зээл авдаг бол ломбарднаар 35-аас доош насны залуучууд илүү их үйлчлүүлдэг байна.

Санхүүгийн байгууллагын сонголтод үйлчилгээний түргэн шуурхай байдал болон барьцаа хөрөнгө, баталгаанд тавигдах шаардлага хамгийн чухал шалгуур болдог байна. Энэ хоёр шалгуур ББСБ, ломбардны хувьд зонхилох шалгуур болдог буюу 70 гаруй хувийг эзэлж байна. Өнөөдөр иргэдийн анхаарлыг нэлээд татаж байгаа зээлийн хүүгийн түвшин арилжааны банкны сонголтод 4, ББСБ-ын сонголтод 5, ХЗХ-ны сонголтод 5, ломбардны сонголтод 3 дахь чухал хүчин зүйл болж байна.



Иргэдийн 18.8 хувь нь хөрөнгийн биржийн арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсан гэж хариулсан бол 51.0 хувь нь үгүй, 30.1 хувь нь мэдэхгүй гэж хариулсан. Үүнийг жилийн өмнөх судалгаанд оролцогсдын 14.0 хувь нь арилжаанд хэрхэн оролцох талаар сонирхож байсантай харьцуулбал иргэдийн хөрөнгийн зах зээлд оролцох сонирхол 4.8 пунктээр өссөн байна. Бүрэн дундаас дээш боловсролтой иргэдийн арилжаанд оролцох сонирхол доогуур боловсролтой иргэдээс 40 хувиар өндөр байна. Эрэгтэйчүүдийн арилжаанд оролцох сонирхол эмэгтэйчүүдээс 1.7 дахин өндөр байна. **ХС**

Давхар бүртгэлийн журам

Хоёр болон түүнээс олон тооны биржид үнэт цаасаа бүртгүүлж, төдий тооны хөрөнгийн зах зээл дээр зэрэг гарах хувьцаат компаниудын бизнесийн үйл ажиллагааг duallisting буюу давхар бүртгэл гэдэг.

Зэрэг гарч буй зах зээлүүдийн ялгаатай нөхцөлүүд харилцан бие биеийнхээ сул, дутагдалтай талыг нөхөж, үнэт цаас гаргагчдад боломж олгодог. Тухайлбал, аль нэг зах зээл дээр хувьцааны хөрвөх чадвар бага, капиталын нөөц хомс, хөрөнгө оруулагчдын идэвх, мэдлэг сул, ногдол ашгийн татвар өндөр зэрэг олон учир дутагдал байж болох бөгөөд энэ тохиолдлууд тухайн үнэт цаасны ханшид сөргөөр нөлөөлж, багаар тогтоход хүргэнэ. Харин нөгөө зах зээл дээр байдал эсрэгээр байгаа нөхцөлд хувьцааны үнэ бодитоор тогтох боломжтой юм.

Хэдийгээр duallisting хийх нь хувьцаат компаниудын өөрсдийн шийдэх асуудал ч гэлээ стратегийн хувьдальбүс нутаг, зах зээлийг сонгох вэ гэдэгт санхүүгийн зохицуулагч байгууллагууд бодлогын чиглүүлэл хийж байдаг. Тиймээс Санхүүгийн зохицуулах хороо 2017 оны 11 дүгээр сард “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай түр журам”-ыг батлан мөрдүүлж эхлээд байна.

Журам батлахын урьдач нөхцөл болох Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагуудын жагсаалтыг Хороо 2017 оны долдугаар сард баталсан. Энэхүү жагсаалтад дэлхийд тэргүүлэгч 26 бирж багтсан бөгөөд жагсаалт дахь биржүүдэд бүртгэлтэй компаниуд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа давхар бүртгүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг ихээхэн хөнгөвчлөх боломж бүрдүүлж буй юм. MSCI, FTSE индексийн ангиллын дагуу “хөгжсөн” орны тоонд багтсан улсын хөрөнгийн биржид анхдагч бүртгэлтэй компаниудад хоёрдогч бүртгэл хийлгэхэд бүрдүүлэх баримт бичиг болон зохицуулалтын дүрэм, журмын шаардлагуудаас тодорхой хэмжээгээр чөлөөлдөг олон улсын нийтлэг жишиг бий.

Монгол Улс эрдэс баялгийн арвин их нөөцтэй, уул уурхайн салбараас хамаарал бүхий эдийн засагтай орон. Манай улсад үйл ажиллагаа явуулдаг, гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудыг салбараар нь авч

үзвэл уул уурхайн салбар зонхилж буй. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудаас 30 орчим нь гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй байдаг. Мөн Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуульд “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд нь хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн бирж дээр арилжина” гэж заасан байдаг. Эдийн засгийн энэхүү гол салбарынхаа өгөөжийг хүртэх, давуу талыг ашиглан олон улсын нэр хүнд бүхий хөрөнгийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн, тэдгээрийн шалгуур, стандартыг

хангасан, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг дотоодын хөрөнгийн зах зээлд гаргах боломж бол яах аргагүй гадаадад бүртгэлтэй компаниудынхаа хувьцааг дотоодын хөрөнгийн биржид арилжаалах явдал юм.

Давхар бүртгэлийн журам нь зургаан зүйлтэй. Нэгдүгээр зүйлээр нийтлэг үндэслэл, холбогдох хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, журмын зорилт зэргийг тодорхойлж, хоёрдугаар зүйлд Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх, гуравдугаар зүйлд гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэх, нийтэд санал болгох, худалдах, дөрөвдугаар зүйлд Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон гадаад улсад бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн эрх, үүрэг, тавдугаар зүйлд гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргасан үнэт цаасыг бүртгэлээс хасах, зургадугаар зүйлд бусад харилцааг тус тус журамласан байна. Журмыг хэрэгжүүлснээр зах зээлд хөрөнгийн нэмэлт эх үүсвэр бий болж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг богино хугацаанд татах бололцоо бүрдэхийн зэрэгцээ санхүүжилтийн зардал буурах, компанийн засаглал болон нягтлан бодох, бүртгэлийн үйл ажиллагаа сайжрах зэрэг эерэг нөлөөтэй. Түүнчлэн хөрөнгийн зах зээлд хувьцааны арилжааны хэмжээ нэмэгдэж, хөрвөх чадвар нь сайжран, үнэт цаасны арилжааны мэргэжлийн зуучлагч байгууллагуудын үйл ажиллагаа эрчимжихийн дээр олон улсад давхар бүртгэлтэй компанийн бизнесийн нэр хүнд дээшилж, улмаар экспорт нэмэгддэг. **ХС**

Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагуудын жагсаалт

№	Арилжаа эрхлэх байгууллагын нэр
1	Австралийн үнэт цаасны бирж /Australian Securities Exchange/
2	Венийн хөрөнгийн бирж /Wiener Börse/
3	Нью-Йоркийн хөрөнгийн бирж /The New York Stock Exchange/
4	Насдак хөрөнгийн бирж /Nasdaq/
5	Брюсселийн хөрөнгийн бирж /Euronext Brussels/
6	Солонгосын хөрөнгийн бирж /Korea Exchange/
7	Хонг Конгийн хөрөнгийн бирж /The Stock Exchange of Hong Kong/
8	Франкфуртын хөрөнгийн бирж /Deutsche Börse/
9	Амстердамын хөрөнгийн бирж /Euronext Amsterdam/
10	Копенгагены хөрөнгийн бирж /Nasdaq Copenhagen/
11	Тель-Авивын хөрөнгийн бирж /Tel-Aviv stock exchange/
12	Ирландын хөрөнгийн бирж /Irish stock exchange/
13	Мадридын хөрөнгийн бирж /Bolsa de Madrid/
14	Италийн хөрөнгийн бирж /Borsa Italiana/
15	Лондонгийн хөрөнгийн бирж /The London Stock Exchange/
16	Шинэ Зеландын хөрөнгийн бирж /New Zealand Stock Exchange/
17	Стокгольмын хөрөнгийн бирж /Nasdaq Stockholm/
18	Швейцарын хөрөнгийн бирж /SIX Swiss Exchange/
19	Торонтогийн хөрөнгийн бирж /Toronto stock exchange/
20	Торонтогийн венчур бирж /Toronto venture exchange/
21	Ослогийн хөрөнгийн бирж /Oslo Børs/
22	Лисабоны хөрөнгийн бирж /Euronext Lisbon/
23	Сингапурын хөрөнгийн бирж /Singapore Exchange/
24	Хельсинкийн хөрөнгийн бирж /Nasdaq Helsinki/
25	Парисын хөрөнгийн бирж /Euronext Paris/
26	Токиогийн хөрөнгийн бирж /Tokyo stock exchange/



Ипотекийн зээлийн даатгал

Санхүүгийн зохицуулах хорооноос орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан айл өрх, иргэд болон зээлдүүлэгч байгууллагыг эрсдэлээс хамгаалах зорилгоор ипотекийн даатгалыг тусгайлан шинээр бий болгон нэвтрүүлж, холбогдох журмыг батлан мөрдүүлж байна. Журамд даатгалын үйл ажиллагаа эрхлэгчид

ипотекийн даатгалын бүтээгдэхүүнээ боловсруулан Хороонд ирүүлж, хянуулах болон бүртгүүлэхээр заасан.

Журам батлагдсанаас хойших нэг жилийн хугацаанд “МИГ даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК, “Ард даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Соёмбо

даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК гэсэн арван нэгэн компани бүтээгдэхүүнээ хянуулж, бүртгүүлээд байна.

Ипотекийн даатгалын бүтээгдэхүүнүүд шинээр бий болсонтой холбогдуулан зээлдэгч-даатгуулагчдад дараах зөвлөмжийг өгч байна.

Даатгагч компани, даатгалын зуучлагч-банкаа сайтар судлаарай!

Даатгалын компани тань “Ипотекийн даатгал”-ын бүтээгдэхүүнүүдээ Хороонд бүртгүүлсэн байх ёстой тул нягтлаарай.

Ипотекийн даатгал нь “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал”, “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал” гэсэн ХОЁР ТӨРЛИЙН бүтээгдэхүүнээс бүрдэх тул Та даатгалын хоёр гэрээ байгуулна.

Даатгалын компанийг эрхлэх үйлчилгээний нөхцөлөөр нь ердийн ба урт хугацааны даатгагч гэж ангилагддаг. Ердийн даатгалын компаниуд ипотекийн

даатгалын бүтээгдэхүүнүүдийг аль алийг нь борлуулах боломжтой бол урт хугацааны даатгалын компани зөвхөн “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг борлуулна.

“Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал”-аар ердийн даатгалын компаниуд зөвхөн гэнэтийн ослын улмаас нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах тохиолдлыг даатгадаг бол урт хугацааны даатгалын компани гэнэтийн осол, өвчний улмаас зэрэг аливаа шалтгаант тохиолдлуудыг даатгана.

Иймд Та даатгалын компани сонгохдоо ипотекийн даатгалын бүтээгдэхүүнүүдийнх нь онцлог, нөхцөл, давуу тал, хураамжийн хэмжээг харгалзан сонгоорой. Хоёр төрлийн бүтээгдэхүүнээ өөр өөр компаниас авсан ч болно.

Ипотекийн зээл олгож байгаа банкуудын дийлэнх нь даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй тул даатгалын компаниуд, бүтээгдэхүүнээс сонголт хийх боломжоор Таныг хангах үүрэгтэй.

Даатгалын бүтээгдэхүүн буюу гэрээний нөхцөлүүдийг судалж, харьцуулаарай!

Даатгалын компаниудын Хороонд хянуулж бүртгүүлсэн ипотекийн даатгалын бүтээгдэхүүнүүд өөр өөрийн онцлог, ялгаатай тул гэрээнийхээ хасалтын болон хамгаалах нөхцөлүүд, даатгалын тохиолдол үүсэхэд бүрдүүлэх баримт бичиг, хураамжийн хэмжээ зэрэгтэй сайтар танилцаж, харьцуулж, асууж, зөвлөгөө аваарай.

Хороонд бүртгэн аваад байгаа Ипотекийн бүтээгдэхүүнүүдийн ялгаатай нөхцөл, зайлшгүй лавлаж тодруулах шаардлагатай харилцааны заримаас танилцуулья.

1. Зарим зээлдэгчид шинээр орон сууц худалдан авах ипотекийн зээлийнхээ урьдчилгаанд хуучин орон сууцаа барьцаалах тохиолдол бий. Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалд зөвхөн шинээр худалдан авсан орон сууцыг даатгах боломжтой. Урьдчилгааны зээлд барьцаалсан орон сууцыг даатгуулах эсэхээ даатгуулагч өөрөө шийдэх ба

даатгуулья гэвэл боломж бий эсэхийг нягтлаарай.

2. Ердийн даатгалын зарим компани даатгуулагчийн нас барах эрсдэлийн шалтгаануудад цус харвалт, зүрх гэнэт зогсох/хаагдах зэргийг нэмэх боломжтой.

3. Барьцаа хөрөнгийг түрээслүүлэх үед даатгалаар хамгаалах эсэх нь компани тус бүрд харилцан адилгүй.

4. Даатгалын тохиолдол гарсан бол 72 цагийн дотор компанидаа мэдэгдэх Таны үүрэг гэрээнд туссан байгаа. Энэ үүргээ биелүүлээгүй бол даатгалын нөхөн төлбөр олгох эсэх талаар гэрээнд заалт байгааг сайн хараарай.

5. Таны банкнаас авсан нийт зээлийн хэмжээнд үндсэн ба хамтран зээлдэгчийн эзлэх хувь даатгалын компаниас авах нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлоход чухал нөлөөтэй. Иймд тус хувийг өөрчлүүлэх талаар даатгалын компани болон банкиндаа хандаж

болох, эсэхийг урьдчилж сайн мэдээрэй.

6. Жирэмслэлтээс үүдсэн даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгох эсэхийг бас сайтар судлаарай.

7. Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, бүр алдсаны аль ч тохиолдолд нөхөн төлбөрийг олгох, эсэхийг магадлаарай.

8. Даатгагч зээлийн хүүгийн төлбөрийг төлөх эсэхийг нягтлаарай.

9. Даатгалын хохирол үнэлгээний зардлыг хэн төлөх талаар асууж тодруулаарай.

10. Таны өөрийн буруугаас үүдсэн даатгалын тохиолдолд нөхөн төлбөр олгох эсэхийг тодруулж мэдээрэй.

11. Монгол Улсаас бусад улсад таны даатгал үйлчлэх эсэхийг гэрээний нөхцөлөөс сайтар судлаарай.

Эцэст нь компаниуд даатгалын хураамжаа Хороонд бүртгүүлсэн хувиас хэтрүүлэх, илүү хураамжийг Танаас шаардах эрхгүйг зөвлөж байна. **ХС**

EVENT CALENDAR 2018

2018 ОНЫ 7 ДУГААР САР

7 ДУГААР САРЫН 7-8

ЖИ 20-ийн дээд хэмжээний уулзалт.
ХБНГУ

7 ДУГААР САРЫН 5-26

ОУХЗХСүлжээний чуулга уулзалт. ИрБНУ.
Дублин

2018 ОНЫ 9 ДҮГЭЭР САР

9 ДҮГЭЭР САРЫН 3

СХН-ийн Бүс нутгийн санаачлагын хурал.
ОХУ

9 ДҮГЭЭР САРЫН 5

СХН-ийн чуулга уулзалт. ОХУ

9 ДҮГЭЭР САРЫН 6-7

СХН-ийн Олон Улсын Бодлогын Форум.
ОХУ

9 ДҮГЭЭР САРЫН 4-5

Даатгалын инновацийн лаборатори.
Монгол Улс. Улаанбаатар

2018 ОНЫ 10 ДУГААР САР

10 ДУГААР САРЫН 13-14

ОУВС болон ДБ-ны чуулга уулзалт.
Индонез Улс. Бали

2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

11 ДҮГЭЭР САРЫН 8-9

Даатгалын хянан шалгагчдын олон улсын
холбооны чуулга уулзалт. Люксембург

9 ДҮГЭЭР САРЫН 14-16

ҮЦХОУБ-ын Санхүүгийн тогтвортой
байдлын институт (FSI)-ийн чуулга
уулзалт. Швейцари

2018 ОНЫ 12 ДУГААР САР

12 ДУГААР САРЫН 7-8

Монголын Санхүү, эдийн засагчдын өдөр.



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

МЭДЭЭЛЛИЙН СУРВАЛЖУУД

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ:



Холбоо барих

+976-51-264444



Цахим хуудас

www.frc.gov.mn



Товхимол

Хүртээмжтэй санхүү

Шинэ



WWW.FACEBOOK.COM

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО



WWW.TWITTER.COM

@FRC_OF_MONGOLIA